

**ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
*2023 оны 05 дугаар сарын 15-ны өдөр, Даваа гараг*

|   |             |
|---|-------------|
| <i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>  | <i>0</i>    |
| <i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>   | <i>1-2</i>  |
| <i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>  | <i>3-34</i> |
| <hr/>   |             |
| <i>1. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.04.28-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i> | <i>3-34</i> |

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы  
Төсвийн байнгын хорооны 05 дугаар сарын 15-ны өдөр  
/Даваа гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 11 гишүүн хүрэлцэн ирж, 57,9 хувийн ирцтэйгээр хуралдаан 12 цаг 13 минутад Төрийн ордны “Жанжсин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Л.Мөнхбаатар, С.Одонтуяа, Д.Өнөрболор.

**Нэг.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.04.28-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ч.Чимидсүрэн, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Э.Батмөнх, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Санхүүгийн зах зээл, даатгалын хэлтсийн дарга Л.Сонор, Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга С.Тулга, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Б.Одонтуяа, Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Ж.Дэлгэржаргал, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн газрын дарга Л.Энх-Амгалан, мөн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга Б.Анар нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ё.Энхсайхан, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх итгэлийг Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн зөвлөмжийн талаарх танилцуулгыг Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга Д.Даваасамбуу нар тус тус танилцуулав.

Илтгэлтэй болон танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн, Ц.Сандаг-Очир, Г.Амартүвшин, Х.Баделхан, С.Ганбаатар, Ж.Батжаргал, Ж.Батсуурь, Г.Тэмүүлэн нарын тавьсан асуултад Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Сангийн сайд Б.Жавхлан, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга Б.Одонтуяа, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга Д.Даваасамбуу нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал үг хэлэв.

**Г.Тэмүүлэн:** Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 4  
Бүгд: 13  
69.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гаргах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурь Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 2 цаг 08 минут үргэлжилж, 19 гишүүнээс 16 гишүүн хүрэлцэн ирж, 84.2 хувийн ирцтэйгээр 14 цаг 21 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**  
ТӨСВИЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА

Г.ТЭМҮҮЛЭН

**Тэмдэглэл хөтөлсөн:**  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ  
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 05 дугаар сарын 15-ны өдөр,  
Даваа гараг  
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар”  
танхим  
12 цаг 13 минут

### ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Г.Тэмүүлэн:** Байнгын хорооныхоо эрхэм гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе ээ. Та бүхэнд юуны өмнө Байнгын хорооны хуралдаанд оролцож байгааг гишүүдийн ирцийг танилцуулъя. Ганзоригийн Тэмүүлэн миний бие, Ганибалын Амартүвшин, Цогт-Очирын Анандбазар, Хавдисламын Баделхан, Жигжидийн Батжаргал, Сайнхүүгийн Ганбаатар, Шатарбалын Раднаасэд, Цэндийн Сандаг-Очир, Дуламдоржийн Тогтохсүрэн, Чимэдийн Хүрэлбаатар, Баттогтохын Чойжилсүрэн гэсэн 11 гишүүн хүрэлцэн ирснээр Байнгын хорооны олонх хүрэлцэн ирчихсэн байна. Ингээд ирц бүрдсэн байна. Төсвийн байнгын хорооны 5 дугаар сарын 15-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье ээ.

Та бүхэнд Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

1 дүгээрт Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл. Засгийн газраас 2023 оны 4 сарын 28-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх асуудал байна аа. Хэлэлцэх асуудалдаа орцгооё.

**Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.04.28-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/**

Танилцуулгыг Монгол Улсын Эдийн засаг, хөгжлийн сайд, Монгол Улсын Шадар сайд Чимэдийн Хүрэлбаатар сайд танилцуулна.

**Ч.Хүрэлбаатар:** Байнгын хорооны дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагад нийцүүлэн боловсруулан хуульд заасан хугацаанд УИХ-д өргөн мэдүүлэн танилцуулж байна.

Дэлхий нийтийг хамарсан цар тахлын төгсгөлтэй залгаад геополитикийн хурцадмал нөхцөл байдлаас улбаатай сүүлийн 40 жилд тохиолдоогүй инфляцын дарамт, урд хөршид тогтоосон хөл, хорио улс орнуудын төв банкнуудын хэрэгжүүлсэн мөнгөний хатуу бодлого зэрэг нь манай улсын эдийн засагт томоохон сорилтыг бий болгож байна. Гэсэн хэдий ч ЗГ өнгөрсөн онд экспортыг нэмэгдүүлж, гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх, эдийн засгийг сэргээхэд чиглэсэн арга хэмжээг үе шаттай авсны үр дүнд 2022 оны 01 дүгээр улиралд 3,9 хувиар агшаад байсан эдийн засаг оны эцэст 4,8 хувиар өслөө. Түүнчлэн 2022 онд 16,9 хувьд хүрч байсан инфляц оны эцэст 13,2, 2023 оны эхний улирлын байдлаар 12 хувьд хүрч харьцангуй тогтворжоод байна.

Монгол Улсын Засгийн газраас сүүлийн 3 жилд хугацаа дууссан арилжааны нөхцөлтэй Засгийн газрын үнэт цааснуудыг эдийн засаг төсөвт дарамт учруулахгүйгээр шийдвэрлэлээ. Тухайлбал 2017 онд болсон 800 сая долларын гэрээг бонд үлдэгдэл төлбөр болох 368,4 сая долларыг өнгөрсөн баасан гарагт бүрэн төлж барагдууллаа. Ингэснээр 2021 оноос хойш нийтдээ 1 тэрбум 650 сая амдолларын өрийн зохицуулалтыг амжилттай хэрэгжүүлж үр дүнд нь өнөөдөр өрийн дефолт өрийн төлбөрөө өрөө амжилттай төллөө.

Экспортын сэргэлт үргэлжилж энэ оны эхний 4 сарын байдлаар нүүрсний экспортыг өмнөх оны мөн үеэс 5 дахин өсгөж, 19 сая тоннд хүрлээ. Экспортын голлох бүтээгдэхүүн нүүрс тээвэрлэлт, борлуулалт үүсээд байсан хүндрэл бэрхшээлийг арилгаж, ил тод нээлттэй болгох, ашигт малтмал тойрсон авлига, албан тушаалын хэргүүдийг хууль хяналтын байгууллагаар шийдвэрлүүлэх зэрэг арга хэмжээ өнгөрсөн 22 оны сүүлээр хэрэгжүүлснийг энэ онд үргэлжлүүлж байна.

Монгол Улс анх удаа нүүрсээ биржээр амжилттай, ил тод, нээлттэй арилжаалж уурхайн ам нөхцөлөөр хямд зарагдаж байсан нүүрсийг хил нөхцөлөөр өндөр үнэтэй борлуулж эхлээд байна. Ингэснээр байгалийн баялгийн үнэ цэн өсөж, Монгол Улсад орох валютын урсгал нэмэгдэж байна. Үүний үр дүнд 2022 оны 01 дүгээр улиралд 1 тэрбум амдолларын алдагдалтай байсан төлбөрийн тэнцэл энэ оны 01 дүгээр улиралд 79,6 сая амдолларын ашигтай болж, улмаар 2,4 тэрбум амдолларт хүрч унаад байсан гадаад валютын албан нөөц энэ оны 4 дүгээр сарын байдлаар 3,7 тэрбум амдолларт хүрлээ.

Дэлхий дахинд эрчим хүчний болон хүнсний үнийн өсөлт 2023 оны эхнээс саарсан, мөн урд хөршид цар тахлын хатуу хөл хориогоо цуцалсан зэрэг нь манай улсын экспортын голлох бүтээгдэхүүний эрэлт болон үнэд эергээр нөлөөлж байна.

Оюутолгойн далд уурхайн үйлдвэрлэл эхэлж, шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд хэрэгжих боомтын болон дэд бүтцийн томоохон төслүүдийн бүтээн байгуулалт эрчимжиж байна. Засгийн газраас эдийн засгийг сэргээх чиглэлээр хэрэгжүүлж байгаа дээр дурдсан арга хэмжээний үр дүнд эдийн засаг 2023 онд 6 хувьд хүрч, цар тахлын өмнөх 2019 оны түвшинээс өсөхөөр байгаагийн зэрэгцээ оны эцэс

гэхэд төсвийн орлого 1 их наяд төгрөгөөр нэмэгдэхээр тооцоолж байна.

Бид эдийн засгаа сэргээх, засаглалаа сайжруулах чиглэлээр богино хугацаанд олсон амжилтаа бататган чармайж ажиллуулах, 2024 онд экспортыг 14,2 тэрбум долларт, гадаад худалдааны ашгийг 4,3 тэрбум долларт хүргэснээр эдийн засаг 6,5 хувиар өсөж, инфляц 8 хувьд хүрч тогтворжих хүлээлт тооцоог хийлээ.

Цаашид экспортыг нэмэгдүүлэх төслүүдэд гол анхаарлаа хандуулан төрөлжүүлэх, аливаа гадаад шокоос эдийн засгийн хамаарлыг бууруулж, эдийн засгийн дархлааг бий болгох нь дунд, урт хугацаанд тогтвортой өсөлтийн суурь байх болно.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлд 2024 онд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг 21 их наяд 163,2 тэрбум төгрөг, нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээг 22 их наяд 996,1 тэрбум төгрөг, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийг 1 их наяд 832,9 тэрбум төгрөг буюу Дотоодын нийт бүтээгдэхүүний -2,8 хувьтай байхаар тооцож Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагуудад бүрэн нийцүүлэн төллөө.

Байнгын хорооны дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Баярлалаа.

**Г.Тэмүүлэн:** Танилцуулга хийсэн Хүрэлбаатар Шадар сайдад баярлалаа.

Байнгын хорооны хуралдаанд Жамбын Батсуурь гишүүн бас хүрэлцэн ирсэн байна. Цэрэнпилийн Даваасүрэн

гишүүн хүрэлцэн ирсэн байна. Бөхчулууны Пүрэвдорж гишүүд бас нэмж орж ирсэн байна. Ингээд чуулганы хуралдаанд нийт 14 гишүүн оролцож байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-26 оны төсвийн төсөөллийн тухай хуульд Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс зөвлөмж гаргасан байгаа. Зөвлөмжтэй холбогдуулаад зөвлөмжийн талаарх танилцуулгыг Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга Даларайн Даваасамбуу дарга танилцуулна. Таныг микрофонд урьж байна. 7 номер.

**Д.Даваасамбуу:** Эрхэм Улсын Их Хурлын гишүүдийн энэ өдрийн амгаланг эрж мэндчилье. Юуны өмнө Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс гаргасан зөвлөмжийг Төсвийн байнгын хорооны хурлаар хэлэлцүүлэхээр ишидсэн явдалд гүн талархалтай байна.

Миний бие цөөхөн зүйл дээр асуудлыг ярьж гэж бодож байна. Манай Төсвийн тогтвортой байдлын тухай хууль маань 2010 онд батлагдсан. Энэ хуулийн маань үндсэн үзэл баримтлал бол байгалийн баялгаа эрчимтэй ашиглах үедээ хуримтлал бий болгоно гэсэн ийм заалттай. Энэ хуримтлал бий болгоно гэсэн заалт нь манай Төсвийн тогтвортой байдлын хуулийн 1 дэх заалт. Хуримтлал бий болгох.

2 дугаарт, 2019 онд Монгол Улс Үндсэн хуульдаа өөрчлөлт оруулсан. Энэ хуулиар байгалийн баялгийн өгөөжийг өнөөгийн ба ирээдүй үедээ тэгш, тэнцвэртэй хуваарилна гэсэн ийм зарчим. Тэгээд эдгээрийг үндэслээд бид саналаа гаргасан.

Ингэхдээ бид төсвийн тогтвортой байдлыг хуулийг мөрдсөнөөс хойш Тогтворжуулалтын сан, Ирээдүй өв сан, Хүний хөгжлийн сан гэх олон төрлийн санг байгуулж, тодорхой үр

дүнд хүрч байсан. Гэхдээ эдгээр сангуудыг бид өнөөдрийн байдлаар үндсэнд нь зарцуулдаг ийм эрх зүйн орчин бүрдүүлчхээд байгаа. Тухайлбал төсвийн тогтвортой байдлын санг төсвийн зардлыг төсвийн алдагдлыг нөхөж зарцуулна гэж хуульчилсан.

2 дугаарт, Ирээдүй өв сангийн мөнгийг 2 жилийн өмнөөс эхлээд Монгол Улсын төсвийн бүрэлдэхүүн хэсэг болгож, Монгол Улсын Сангийн яамны сайдын багцад хуваарилж орлогыг нь өөрөө, орлогыг нь төсвийн бүрэлдэхүүн болгож, зардлыг нь мөн бас төсвийн бүрэлдэхүүн буюу хүүхдийн мөнгөнд хуваарилдаг ийм тогтолцоо бүрдсэн. Энэ юуг харуулж байна вэ гэхээр бид цаашидаа энэ 2 сангаар дамжуулж, нөгөө бидний Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн үндсэн зорилт болсон хуримтлалыг хэрэгжүүлэхэд хүндрэл учрах нь ээ гэсэн ийм ойлголттой байгаа.

Тийм учраас бид энэ төсвийн тогтвортой байдлын хуулийнхаа үндсэн үзэл баримтлал буюу хуримтлал бий болгох, ялангуяа байгалийн баялгийг эрчимтэй ашиглаж байгаа өнөөгийн үе ялангуяа энэ нүүрс, 2 жилийн дараагаас хамгийн эрчимтэй ашиглах зэс зэрэг баялгийг ашиглаж байгаа энэ өнөө үед төсвийг Монгол Улсад хуримтлал бий болгох явдал нэн чухал болжээ.

Дээрээс нь Монгол Улсын хөгжлийг 50 он хүртэл хөгжүүлэх зорилт, сэргээх томоохон төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлэхэд урт хугацаатай хөрөнгийн эх үүсвэрүүд шаардлагатай байгаа. Энэ бүхнийг бодолцоод дэлхий нийтийн жишиг буюу нийгмийн даатгалын системээр дамжуулж хуримтлал бий болгодог системийг Монголд бүрдүүлэх нь зүйтэй гэсэн саналд хүрсэн байгаа. Тухайлбал НДШ-ээс өндөр настны шимтгэл төлөгддөг хувь хүнийх, ажил олгогчдын хэсгээс хувь хүний төлдгийг шууд дансанд нь олгоё. Өөрөөр хэлэх юм бол 2,4 их наяд төгрөгийн тэтгэврийн



сангийн тал орчим хувь нь буюу 1,3 их наяд төгрөг нь хувь хүмүүсийн НДШ болж, цаашидаа хуримтлал болно.

Ингэхгүйгээр бид хүмүүсээ даатгалд хамаарагддаг сонирхлыг бүрдүүлж чадахгүй. Нөгөө талаас даатгалын хамралт улам бүр багасаад байх ийм төлөв ажиглагдаж байна.

Дээрээс нь байгалийн баялаг бүхий орнууд бүгд энэ хэлбэрт хүрсэн, ийм хэлбэртэй болсон. Жишээлбэл Австрали албан журмын даатгалтай, бид ойрхон хөршөө харъя. Бүгд Найрамдах Хятад Ард Улс бол нийгмийн даатгалын шимтгэлийг ажил олгогчийнх нь төсөвтөө авч, даатгалынхаа санд авч, суурь тэтгэврийг шийдвэрлэж байгаа. Хувь хүмүүсийнх нь бол өөрийнх нь дансанд хадгаламж хэлбэрээр ашиглаж байгаа. Энэ олон улсын жишиг бол үндсэндээ хориод жилийн өмнөөс эхэлсэн бөгөөд өнөөдөр бид бараг сүүл мушгих гэх хэлбэр лүү орж байна. Тийм учраас энэ хуримтлалын систем рүү шилжихгүйгээр энэ нийгмийн даатгал болон төсвийг цаашид эрүүлжүүлэхэд нэлээн хүндрэл учирна гэж үзэж байгаа.

Нөгөө талаасаа бид баялгаа нэн эрчимтэй ашиглаж байгаа үед сэргээгдэх хуримтлалтай болно гэдэг хуульдаа заачихсан юм. Сэргээгдэх эх үүсвэртэй болно гэж. Өөрөөр хэлэх юм бол Оюутолгой, Тавантолгойн ашиглалт 30 жилийн дараа багаслаа гэж үзвэл үүнээс үүссэн нийгмийн даатгалын хуримтлал буюу нэг 50-60 их наяд төгрөг маань өөрөө Монгол Улсыг цааш нь хөтлөөд явах хөгжлийн гол хөшүүрэг болно гэсэн концепцын үүднээс ярьж байна.

Тийм учраас бид цаашидаа төсвийн алдагдлыг буюу нийгмийн даатгалын шимтгэлийн алдагдал буюу өндөр насны тэтгэврийн хувь хүмүүсээс гарч байгаа хэмжээнд нь барьж, хувь хүмүүст нь нийгмийн даатгалын шимтгэлийн дансанд оруулъя. Чингэхдээ бид 5 жилийн

дараагаас хүмүүст сонголтыг нь өгье. Эхний ээл 5 жилдээ хүмүүс цэвэр Монгол Улсын систем нь ач холбогдолтой банкнуудыг сонгоё.

Тэгээд 5 жилийн дараа сонгож хадгаламжаа байршуулж байя, 5 жилийн дараагаас хөрөнгийн зах зээл буюу хувьцаа, хөрөнгө оруулалтын санд олгодог системийг тогтоож өгье. Энэ хүртэл бид холбогдох хууль, дүрэм, журмыг нь тогтооё гэсэн ийм агуулгатайгаар явъя.

Цаашидаа 20 жилийн дотор өнөөдрийн Ирээдүй өв сан болон Тогтвортой хөгжлийн тогтворжуулалтын сангийн орлогоороо энэ нийгмийн даатгалынхаа алдагдлыг цэгцлээд суурь тэтгэврийнхээ систем рүү 15-20 жилийн дараа орчихно гэсэн ийм тооцоо судалгаанууд хийгдсэн байгаа. Энэ маань өөрөө бид нар энэ төрийн мэдэлд байдаг сангаа хувь хүмүүсийн мэдэлд өгч зарцуулах, ингэснээр Монгол Улсад цаашидаа урт хугацаанд хөрөнгийн эх үүсвэр бий болох, ялангуяа томоохон хэмжээнд төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх эх үүсвэр бүрдэнэ гэсэн ойлголттой. Энэ маань өөрөө дэлхий нийтийн жишиг гэж ойлгож байгаа.

Бид өнөөдөр энэ даатгалын системтэй Америк гэхэд ухаан нь Америкийн хуримтлал нь дотоодынхоо нийт бүтээгдэхүүний 1,3 хувьтай тэнцэж байна. Хятадынх НДШ нь хувь хүмүүсийнх нь шимтгэл өгдөг өөрсдийнх нь дансанд ордог учраас далд эдийн засгийг бол үндсэнд нь байхгүй болгосон. Хүн бүхэн ажил л хийж байвал, даатгалынхаа мөнгийг өөртөө авах ийм сонирхолтой болсон. Энэ маань маш олон төрлийн ач холбогдолтой шүү. Ялангуяа өнөөгийн нөхцөлд энэ далд эдийн засгийг илрүүлж засах үндсэн арга НДШ-ийг хувь хүмүүсийнх нь дансан дээр өгөх явдал гэж ойлгож ийм санал оруулж байгаа.

Бусад саналуудын хувьд манай Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Бямбажав гуай ярина гэж та бүгдэд танилцуулна. Ингээд анхаарал тавьсанд баярлалаа. Бид танилцуулгаа тараачихсан, илтгэлээ слайдаар бэлдчихсэн байгаа бас тараачихъя. Би зүгээр товчлоод ярьчихлаа шүү, дарга нар аа, уучлаарай. Баярлалаа.

**Г.Тэмүүжин:** Даваасамбуу даргад баярлалаа.

Та бүхэнд ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя.

Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Мижиддоржийн Санжаадорж, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Бямбарагчаагийн Тэлмүүн, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Чойгүнсэнгийн Чимэдсүрэн, Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга Зоригтбаатарын Энхболд, Сангийн яамны Санхүү төсвийн судалгааны газрын дарга Ганболдын Золбоо, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн Засгийн газрын дарга Лхагвабаярын Энх-Амгалан, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга Бат-Ирээдүйн Анар, Сангийн яамны Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Энхтөрийн Батмөнх, Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн дарга Пүрэвдоржийн Бат-Эрдэнэ, Сангийн яамны Төсвийн орлогын хэлтсийн дарга Лувсанвандангийн Ичинноров, Сангийн яамны Санхүүгийн зах зээл, даатгалын хэлтсийн дарга Лувсандоржийн Сонор, Сангийн яамны Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга Солонгын Тулга, Сангийн яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга Байгалмаагийн Одонтуяа, Сангийн яамны Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Жамьяншаравын Дэлгэржаргал, Сангийн яамны хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Булганхүүгийн Ганзориг.

Хуулийн төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Гишүүдийн нэрсийг авъя. Батсуурь гишүүнээр тасаллаа. Тогтохсүрэн гишүүн.

**Д.Тогтохсүрэн:** Баярлалаа. 2024 оны төсвийн хүрээний мэдэгдлийг хэлэлцэж байна, 24 он ямар байх вэ гэдэг. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс бас тодорхой хэмжээний зөвлөмж өгсөн байна. Би ингээд нэг 3, 4 асуулт асууя гэж бодож байна.

Сая бид нар чинь хөдөө орон нутагт бас нэлээн олон сумаар ажиллалаа, ард иргэдтэйгээ уулзалт хийлээ. Тэгээд хамгийн их бухимдаж байгаа асуудал бол энэ инфляц, үнийн өсөлт байгаа юм. Үнэхээр хүмүүсийн хамгийн их бухимдал үүсгэж байгаа юм. Бид нар ч яах вэ яриад л байгаа. Зарим төрлийн барааны үнэ 100 хувь нэмэгдсэн гээд ингээд их бухимдал ихтэй байгаа юм. Тэгээд би Сангийн яамнаас асуух гэж байгаа юм.

Ер нь энэ үнийн өөрчлөлттэй холбогдуулж, Сангийн яам болон бусад яамд, ЗГ судалгаа хийсэн юм байна уу. Энэ нийлүүлэлтээсээ шалтгаалсан үнийн өсөлт байна уу? Ханшаасаа шалтгаалсан үнийн өсөлт байна уу? Тэвэр ложистикоос шалтгаалсан үнийн өсөлт байна уу? Энэ юунаас шалтгаалсан үнийн өсөлт вэ. БНХАУ-д харьцангуй тийшээ явж бизнес хийдэг хүмүүс, бизнесүүд ярьж байгаа юм. БНХАУ бол ковидын дараа үнэ нь нэлээд хэмжээгээр буурсан, тэвэр ложистикийн зардал 2-3 дахин буурчихсан ковидын үеийнхээсээ гээд байгаа. Гэтэл Монголдуудаггүй ээ, хэрэглэгч дээрээ очихоороо бүр буухгүй ингээд бүр өсөөд байгаа юм. Тэгэхээр энэ талаар яг судалгаа хийгээд юун дээрээ үндэслэж үнийн өсөлт гарсан, энэ нь ямар буурах боломж байна вэ гэдэг асуудал байгаа юм.

2 дугаар асуудал нь тухайлбал энэ 1 дүгээр асуудал дээрээ хэлэхэд



дотоодын бүтээгдэхүүнүүдийн үнэ өсөөд байгаа байхгүй юу. Тухайлбал гурил 100 хувь өссөн гурилыг. Энийг хүмүүс их шүүмжилж байгаа юм. Тариаг өөрөө тарьсан, шатахууныг нь зарим хэсгийг нь үндсэндээ төр барьж байна, 92 бензин. Гэтэл гурил 100 хувь нэмэгдсэн гээд ингээд бухимдаад байгаа юм.

2 дахь асуудал нь энэ үнийн өсөлтийн чиглэлээр нийлүүлэлтийг нэмэгдүүлэх, үнийн өсөлтөө бууруулах. Энэ чиглэлээр яг Засгийн газраас тодорхой яг ямар арга хэмжээ авч хэрэгжүүлэв гэдгийг 2-т нь асуумаар байгаа юм.

3 дахь асуудал бол сая Даваасамбуу гуайн илтгэлд их тодорхой дурдаж байгаа асуудал байгаа юм. Энэ хуримтлал бий болгох асуудал байгаа юм. Бид нар ингээд л өнөөдөр зах зээл дээр нүүрсний үнэ гайгүй байна, зэсийн үнэ гайгүй байна, төмрийн хүдрийн үнэ гайгүй байна, алтны үнэ гайгүй байна. Гэтэл бид нар хуримтлал бий болгож чадахгүй ингээд л гаргаад л идэж уугаад байгаа юм. 24 онд ер нь хуримтлал бий болгох чиглэлээр энэ төсвийн хүрээний мэдэгдэлд тодорхой туссан асуудал байна уу? Ер нь бид нар хуримтлалыг бий болгож байгаад л энэ хуримтлалаас явах, ер нь Ирээдүйн өв сан бол хуримтлал байсан. Тэгээд төсвийн бүрэлдэхүүн хэсэг болгоод төсөвт өгөөд, хүүхдийн мөнгөнд өгөөд ингээд явчхаж байгаа юм. Тэгэхээр энэ хуримтлалын асуудлыг би тодруулж 3 дугаарт нь асууя гэж бодож байгаа юм.

4 дүгээрт нь гадаад өртэй холбоотой асуудал байгаа юм. 33 тэрбум долларын өр байна, улсын өр. Үүний Засгийн газрын өр нь 8 тэрбум доллар байна. Мэдээж Засгийн газрын өрөө бол эрсдэлгүй явж байгаа, үүнийг бол ойлгож байгаа. Гэхдээ хани өсөөд байгаа, хани өсөхөөр манай төсөв дээр ирэх ачаалал нэмэгдэж байгаа. Цаашидаа төлөх бидэнд ачаалал үүсэж байгаа. Тэгэхээр 24 онд ямар хэмжээний өрийг төлөхөөр

төлөвлөж байгаа вэ, урьдчилж юм уу, хүүн дээрээ менежмент хийх, бага хүүтэй болох чиглэлээр ирэх онд хийгдэх ажил байна уу гэсэн ийм 4 зүйлийг би Сангийн яамнаас асууя.

**Г.Тэмүүлэн:** Тогтохсүрэн гишүүний асуултад хариулъя. Шадар сайд Хүрэлбаатар.

**Ч.Хүрэлбаатар:** Инфляцын талаар хуримтлал, өрийн тухай хариулъя. Инфляц бол үндсэндээ 16,7 хувьд хүрсэн. Яг ингэхдээ энэ инфляцыг барих гээд бид нар чинь хууль ч баталж үзсэн. Тэгээд энэ нөгөө хууль батлаад, бараа бүтээгдэхүүний үнэ баригдахад бас их төвөгтэй байдаг. Эргээд тэр юу гэдэг юм, долларыг нь хямдхан өглөө ч гэсэн эргээд тэр нь тодорхой хугацааны дараа эргээд хэвдээ ороход тэр зөрөөгөөрөө эргээд огцом нэмэгдэх бас их эрсдэлтэй байдаг. Тэгээд зүгээр түр зуурын арга хэмжээ болж хувирах тийм эрсдэлтэй байдаг. Тэгээд инфляцдаа бууруулъя гэж байгаа бол ерөөсөө л макро эдийн засгийн үндсэн гол бодлогуудаа бол зөв болгоод явах ёстой. ЗГ, Монголбанкны хувьд бол хэрэгжүүлж байгаа мөнгөний бодлого, төсвийн бодлого бол би зөв байгаа гэж үзэж байгаа. Энэ нь ч бас эерэг үр дүн өгч байгаа.

Ер нь нэг суурь шалтгаануудыг нь аваад үзэх юм бол одоо юу гэдэг юм. Ковидын үед бусад улс орнууд чинь бас хорио хоригтой байсан, нөгөө нэг хөл хорио хорьчихсон байсантай холбоотойгоор ер нь ихэнх улс, газрууд чинь үйлдвэрүүд хэвийн журмаар ажиллах боломжгүй болдог. Үүнтэй холбоотойгоор бараа бүтээгдэхүүний нийлүүлэлт буурдаг. Улс орнууд хоорондоо хилээ хаачихсан байсан учраас улс орон дамжсан тээврүүдээр үнэ өртөг өсдөг. Энэ нь төвөгтэй учраас л үнэ өсөөд, үнэ өсдөг ийм зүйлүүд байсан. Тэгээд энэ бүгд бол хэвийн болоод, яг тээвэрлэлтийн зардлууд бол нэлээн буугаад явж байгаа. Энэ нь эргээд энэ

инфляцын түвшнийг 5 сарын 8-ны байдлаар 10,8 байна. Тэгэхээр 16, 17-гоос 7-гоос доошоо буугаад 10 руу явахад бас энэ зүйлүүд бол явагдаж байгаа ингээд. Энэ дээрээс бид нар цаашидаа гол анхаарах зүйл гэвэл энэ нийлүүлэлтийг л яаж нэмэгдүүлэх вэ, яаж энэ нэг хиймэл хүнд суртал, хориг саад, бэрхшээл багатай байх вэ гэдэг дээрээ л онцгойлж анхаарах ёстой.

Дээр нь үндсэндээ 22 онд бол валютын хани 2844-3540 болоод 22 хувиар уналаа. Энэ нь эргээд бас инфляцад бол тодорхой хэмжээний нөлөө үзүүлсэн. Одоо бол валютын нөөц нэмэгдэж байна. Хани тогтворжих бүрэн нөхцөл бол бүрдээд явж байгаа учраас инфляц дээр ирэх бол дарамт бол байхгүй. Тэгэхээр өмнөх хани 2844-3540 болж 22 орчим хувиар унасан нь энэ нь өөрөө инфляцад бол нэлээд их хэмжээний нөлөө үзүүлсэн бас суурь нөлөөллийн нэг нь бол энэ хани байсан гэдгийг би бол хэлмээр байна. Тэгээд ерөнхийдөө саяын хэлэлцэгдсэн зүйлүүд бол хэвийн орж байгаа.

Хуримтлалыг бий болгох уу гэж байгаа. Яг энэ төсвийн хүрээний мэдэгдэл болон төсвийн төсөөллийг өргөн мэдүүлэхдээ одоо байгаа яг хуулийн хүрээндээ л бид нар өргөн мэдүүлсэн. Тэгэхээр түүн дээр хуримтлал үүсдэг ганцхан сан явж байгаа шүү дээ. Ирээдүй өв сан. Ирээдүй өв сан дээр тодорхой хэмжээний хуримтлалууд бол байгаа. 2023 онд бол ирээдүй өв санд бол 2,4 их наяд төгрөгийн орлого хуваарилагдаж байгаа. Тэгэхээр нийтдээ 2,4 их наяд гэж тооцож болно.

Тэр тэтгэврийн сан нэрийн дансанд шилжих тухай бас хэн Даваасүрэн ярьж байна. Тэтгэврийн нэрийн дансанд, өөрөөр хэлбэл хувь хүн өөрийнхөө нэр дээр дансаа шилжүүлдэг, түүнээсээ тэтгэврээ авч явдаг ийм тогтолцоо руу гээд бид нар хууль, эрх зүйн орчнуудыг нь тодорхой болгож

байж дараагийн алхмууд бол хийгдэх юм. Тэгэхээр яг одоогийн ... /минут дуусав/

**Г.Тэмүүлэн:** Хүрэлбаатар сайдын минутыг нэмье.

**Ч.Хүрэлбаатар:** Одоогийн өргөн мэдүүлсэн байгаа энэ тоонд бол одоогийнхоо хууль дээр нийцүүлээд өргөн мэдүүлчихсэн байгаа гэдгээ хэлье.

Өрийн хувьд бол энд Засгийн газрын энэ өрийн нийт хэмжээ гээд 24 онд 39, 25 онд 43, 26 онд 47 их наяд гээд тавьчихсан байгаа. Энэ нөгөө Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд байгаа хязгаар гээд тоо заачихсан байгаа шүү дээ. Яг тэр хязгаараараа тооцоод тооцоод тавьчихсан. Яг энэ бол хамгийн дээд хязгаар нь л гэж та бүгд ойлгож болно гэдгийг хэлье.

**Г.Тэмүүлэн:** Гадаад өртэй холбоотойгоор 2024 онд төлөх өр, бондыг нэрлэхийг хүссэн. Сая Тогтохсүрэн гишүүн. Мөн дээрээс нь өрийн удирдлага төлөвлөгөөг 2024 онд яаж төлөвлөж байгаа, энэ талаар бас хэлэхийг хүссэн байгаа. Тэгэхээр ажлын хэсгээс нэмж тодруулж хариулах уу? Хэн хариулах вэ? 6 номер.

Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга Одонтүяа гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр Засгийн газрын гадаад өрийн хувьд 2023-25 оны Их Хурлаас батлагдсан стратегийн баримт бичгийг даган мөрдөж байгаа. Тухайн баримт бичигт Засгийн газрын өрийг аль болохоор улсын төсвөөс төлж барагдуулах, валютын ханшийн эрсдэлийг бууруулах, өрийн зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх зэрэг зорилтуудыг дэвшүүлсэн байдаг. Засгийн газрын гадаад өрийн үйлчилгээний хувьд бол 2024 онд 2, 3 дугаар сард төлөгдөх Хуралдай бондын 391 сая амдолларын үндсэн төлбөр, хүүгийн төлбөрт 299 сая амдоллар, гадаад зээлийн үндсэн

төлбөрт 380 сая амдолларын төлбөрүүдийг төлөх тус тус хуваарьтай байна.

Эдгээр ерөнхийдөө хүүгийн зардлыг бууруулах нэг жилд ирэх төсөвт ирэх төлбөрийн дарамтыг бууруулах зорилгоор бол жишээлбэл 2022 оны 12 дугаар сард 23, 24 онд төлөгдөх байсан гадаад бондын үлдэгдлүүдээс хугацаанаас нь өмнө 15,8 сая амдолларыг буцаан худалдан авч, 23, 24 оны гадаад валютын хани болон тухайн онуудад ирж байсан төлбөрийн ачааллыг бууруулах зэрэг шат дараатай арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн байгаа.

Мөн хүүгийн зардлыг 23, 24 онд бас бууруулах зорилгоор Сенчури нэг өрийн зохицуулалтыг 23 оны 1 дүгээр сард авч хэрэгжүүлсэн байдаг.

**Г.Тэмүүлэн:** Сандаг-Очир гишүүн.

**Ц.Сандаг-Очир:** Би сая тойрогтоо ажиллаад ирсэн л дээ, гишүүд. Ерөөсөө ард иргэд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөс илүүтэй энэ эдийн засгийн өсөлт, ард иргэдийн амьдралд яаж, хэзээ нөлөөлөх юм, ЗГ яаж арга хэмжээ авах гэж байгаа юм бэ л гэж байна. Тэгээд сая Шадар сайдын Эдийн засгийн, хөгжлийн сайдын яриагаар бол том эдийн засгийн утгаараа макро түвшинд эдийн засгийн өсөлт бол сайжирч байгаа юм байна. Одоо энэ эдийн засгийн өсөлтүүд, үзүүлэлтүүд яг айл өрхөд, ард иргэдэд яаж хүрэх юм бэ, Засгийн газраас цалин, тэтгэвэр, тэтгэмжийг нэмэгдүүлэх бодлогыг хэзээ авч хэрэгжүүлэх гэж байна вэ? Тэгэхгүй бол ер нь энэ үнийн өсөлтийг гүйцэхгүй. Үнэхээр ард иргэдийн амьдрал бол маш хүнд байгааг олон иргэд шүүмжилж ярьж байна, шүүмжилж ярьж байна. Тийм учраас энэ том эдийн засгийн макро түвшний үзүүлэлтүүд сайжирч байгаа хэрээр ард иргэдийн амьдралд яаж буух вэ гэдэг талаар ирэх жилд яаж төлөвлөсөн юм

бэ. Цалин, тэтгэвэр тэтгэмжид хэдэн төгрөг төлөвлөж байгаа юм.

Тэтгэврийн багц хуулиар нэлээн олон шинэчлэл хийхээр дагаад төсөв дээр нэлээн их хэмжээний хөрөнгө оруулалт шаардлагатай байж байж, энэ нийгмийн даатгалын багц хууль явах байх. Тэгэхээр ирэх жилийн төлөвлөгөө дээр төсвийн хүрээний мэдэгдэлд энэ нийгмийн даатгалын багц хууль, тэтгэврийн шинэчлэл дээр хэдэн төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж, тэр нь эргээд эдийн засагт төсөвт яаж ачаалал болж байгаа вэ гэдгийг нэгд асууя.

2-т, 24 оны эдийн засгийн өсөлтийг 6,5 хувиар тооцсон байна, та бүхэн. Гэтэл Олон улсын валютын сан чинь 5,5хувь байна гэхихсэн, Дэлхийн банк чинь 6,3 хувь байна гээд, Азийн хөгжлийн банк чинь 6,1 хувь байна гээд ингээд ялгаатай байдлаар төсөөлөл гаргачихжээ. Тэгээд та бүхэн бол нэлээн өөдрөгөөр төсөөлсөн байна. Энэ 6,5 хувьд хүрэх бодит бололцоо байгаа юу, үгүй юу гэдгийг, энийгээ нэг тодорхойлж тайлбарлаж өгөөч?

Өрийн хэмжээ 3,8 их наяд төгрөгөөр буюу 35,4 их наядоос 39,3 их наяд төгрөг болж, Засгийн газрын гадаад өрийн хэмжээ нэмэгдэхээр тусгасан байна. Өрийг дараад байгаа, тэгээд ингэж нэмэгдээд байгаа бодит шалтгаан нь юу байна вэ? Энийгээ нэг тодорхой тайлбарлаж өгөөч.

Мөн зардлын хэмжээ өссөн байна. 12,3 хувиар, энэ өсөлтөд юу нөлөөлж байгаа вэ? Энийг нэг тайлбарлаж өгөөч.

Хөрөнгө оруулалтыг 5,8 их наяд төгрөг байхаар тусгасан байна, нийт. Хөрөнгө оруулалт дотроо томоохон улсын хэмжээнд ирэх жил юу юун дээр анхаарч, юу юу хийхээр төлөвлөсөн юм. Шаардлагатай томоохон хөрөнгө оруулалтуудыг бас тайлбарлаж өгөөч. Ийм зүйлүүд дээр та бүхэн нэг тайлбарлаад өгөөч.

**Г.Тэмүүлэн:** Тодорхой асуултууд асуулаа. Жавхлан сайд асуултад хариулъя.

**Б.Жавхлан:** Байнгын хорооны гишүүдийнхээ өдрийн мэндийг эрбье. Эдгээр тоонууд маань ирэх жилийн манай төсвийн гол параметруудийн хязгаар тоонууд шүү гэдгийг дахиж хэлье. Зардлын хувьд бид энэ хүрээндээ бид баригдах ёстой л гэсэн ийм санаа юм байгаа юм. Энэ дотор зардал нэмэгдэж байгаа зүйлүүд байгаа. Энэ дандаа 23 онд гарсан хууль, 22 онд гарсан хууль. Жишээлбэл энэ жилийн нийгмийн даатгалын шинэ хуулийн нөлөөлөл 900 тэрбум, мөн энэ Засгийн газрын өрийн та хүсэлтийг хэллээ. Энэ бол 1 дүгээрт ханшийн зөрөөний хүсэлт байгаа. Мөн 22 онд 9,4 тэрбум долларын гүйцэтгэлтэй гарсан байгаа. Өөрөөр хэлбэл бид төсөв дээр хамгийн их дарамттай байдаг, эдийн засгийн өгөөж муутай, бондын өрийг бол сүүлийн жилүүдэд 3 жил дараалаад бид нийтдээ зөвхөн бонд дээр нь хэлж байна шүү, зөвхөн бонд дээр нь. Бид нар 2,8 тэрбум төгрөгийн долларын зохицуулалт хийсэн. Үүнээс 650-аад сая долларыг төсөв дээрээс 3 жилийн хугацаанд нийтдээ төлж барагдуулсан байгаа юм.

Харин ДНБ өсөхийн хэрээр бид үүнд багтах хязгаар буюу 50 хувьдаа Засгийн газрын нийт өрийг яг бариад явж байгаа. Энэ хооронд харин өрийн дунд хугацааны стратегийн хүрээнд олон талт хөгжлийн түнши институтуудаас Олон улсын валютын сан, Дэлхийн Банк, АХБ-нуудаас урд нь гэрээлэгдсэн урд нь Улсын Их Хурлаар ерөнхийлөн батлагдсан хүрээнд, шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд, хөрөнгө оруулалтуудад хийгдэх, мөн нийгмийн суурь салбарууд дээр хийгдэх дэд бүтцийн ийм урт хугацааны төсөвт бага дарамттай, бага хүүтэй ийм зээлүүд бол Их Хурлаар соёрхон батлагдсан. Тэр хүрээндээ ингээд аваад явж байгаа. Жил бүр бид 1,5-2 их наяд төгрөгийн шүү, төгрөгийн үндсэн зээл, зээлийн хүүг бид

төсөв дээрээ тусгаад ингээд төлөөд явж байгаа. Тэрний зөрөө, үр дүн ирэх оны эцсээр тэгж гарна гэсэн үг.

Хөрөнгө оруулалтын тоог та маш тодорхой асуулаа, 5,8 их наяд байгаа. Үүний 22 оны түвшинд зөвхөн хийгдэнэ, улсын төсвийн хөрөнгө оруулалт, гадаад зээл, тусламж, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт бүгд багтаад шүү, бүгд багтааг гэсэн үг. Үүнийг бол яг задалж ярих бол арай болоогүй. Энд бол бид нар зөвхөн хязгаараа тавьж байгаа юм. Төсөв өргөн баригдах үед бол үүнийгээ задалж ярих ийм цаг нь болно гэсэн үг.

Эдийн засгийн өсөлтийг Эдийн засгийн хуулийн яамнаас харуулах байх.

**Г.Тэмүүлэн:** Зардлын өсөлт 12,3 хувиар өссөн гэдэг асуултыг бас тодорхой асуусан байх тийм ээ. 35,4 их наядаас 39,3 их наяд болж өсөж байна. өмнөх онтой харьцуулахад гэдэг асуудлыг тавьсан.

**Б.Жавхлан:** Тэр чинь Засгийн газрын өр л дөө. Засгийн газрын өр 35,4-39,2 их наяд гэдэг нь зөрөө 3,8-ыг нь түрүүн би тайлбарлалаа, тийм ээ, тийм.

Би тэр төсвийн зардлыг тусад нь ярья, дахиад тайлбарлая. Нэгдсэн төсвийн нийт зардлын дээд хязгаар ... /минут дуусав/

**Г.Тэмүүлэн:** Жавхлан сайдын микрофоныг өгье.

**Б.Жавхлан:** Нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ 20,4 их наядаас 22,9 буюу 2,5 их наядаар ингээд нэмэгдэж байгаа юм. ДНБ-ийхээ 35 хувь, өсөлт нь 7 хувьтай шүү, 7 хувьтай ингээж гарч байгаа. Энэ дээр бид нар ер нь үйл ажиллагааны зардал, урсгал зардал дээр нэлээн өсөлтүүд гарч ирж байгаа. Энэ дотор бид цалингийн нэмэгдэлгүй тодорхой хэмжээнд тооцсон байгаа. Энэ жилийн хувьд бид



нэгэнт батлагдсан төсвөөрөө явж байгаа ийм л зүйлүүд байгаа.

Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон нийгмийн салбарын сургууль, цэцэрлэг гээд 22 онд, 21 онд, 23 онд ашиглалтад орох нэлээдгүй хөрөнгө оруулалтууд байгаа. Үүнийг дагасан урсгал зардлууд, үүнийг Сандаг-Очир гишүүнд бид задлаад хүргэж болно шүү. Тэгээд бид нар одоогоор зүгээр дандаа төлөвлөлтийн хэмжээнд байгаа, зүгээр энэ хязгаар тоонууд нь тавигдсан гэж ойлгоорой.

**Г.Тэмүүлэн:** Хүрэлбаатар сайд нэмж хариулъя.

**Ч.Хүрэлбаатар:** Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. Эдийн засгийн өсөлт 6,5 болоход хэр итгэл үнэмшилтэй байгаа вэ гэж байгаа юм. Хэд хэдэн ч цаана нь шалтгаан байгаа юм.

1 дүгээрт нь, Олон улсын валютын сан 2023 оны эдийн засгийн өсөлтийг 2,8 гэж тооцсон бол, 2024 оныхыг 3 хувь гэж тооцож байгаа. Өөрөөр хэлбэл дэлхийн эдийн засаг бол өснө гэдэг, 1.

2 дугаарт нь, ер нь энэ экспортын орлого бол их олон юмны зангилаа их байдаг. Тэгэхээр экспорт түлхүү явах юм бол экспортын орлого өндөр байх юм бол манай улсын эдийн засагт бол их чухал байдаг. Тэгэхээр Биржийн тухай хууль хэрэгжээд 7 сарын 1-нээс бүрэн утгаараа хэрэгжинэ. Биржийн хууль хэрэгжээд эхлэхээр бид нар нүүрсэн дээр нэмээд зэсээ биржээр зарна, төмрөө зарна, бүгдийг нь зарна, биржээр. Ингэхээр бид нар Эдийн засгийн яам юу гэж бодож байгаа вэ гэхээрээ экспортын орлогоо бид нар одоо байгаагаасаа илүү олох бүрэн боломж байгаа, одоо байгаа өндөр үнээр зарах боломжтой илүү орлого олох боломжтой гэж үзэж байгаа. Тэгэхээр

бид нар экспорт дээрээ нэлээд найдаж байгаа.

Дараагийн зүйл бол юу гэдэг юм, 22 онд чинь яг экспортын хил рүү, экспортын зах зээл рүүгээ нийтдээ нэг 500 орчим километр төмөр зам барьчихлаа шүү дээ. Тэгэхээр тэд нар холбогдоно. Тэгэхээр энэ дээр бас тодорхой юу, ядахдаа нэг нь холбогдоно. Нөгөө Гашиун сухайт бол арай болоогүй байх. Гэхдээ тэр хавиараа бас тээвэрлэлтүүд нэмэгдэнэ шүү дээ, гарч байгаа нүүрс. Тэгэхээр бид нар бол экспорт дээр, мөн боомтууд дээр тодорхой хэмжээний ажлууд хийгдэж байгаа. Сая Замын-Үүдийн зөвхөн зорчигч тээвэр нь ашиглалтад орсон бол ачаа тээвэр нь орно, Гашиун сухайт орно, бусад боомтууд ингээд ашиглалтад ороод эхлэх бол экспорт нэмэгдэнэ гэж үзэж байгаа.

Дээр нь ерөнхийдөө энэ шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд авч хэрэгжүүлж байгаа бас нэлээдгүй бүтээн байгуулалтын ажлууд бол цаашидаа үргэлжлээд явж байгаа учраас бид нар эдийн засгийн өсөлттэй бол итгэлтэй байгаа. Тийм учраас 6,5 хувь гэсэн ийм тооцоогоор бол явж байгаа гэдгээ хэлье.

**Г.Тэмүүлэн:** Сандаг-Очир гишүүн нэмж тодруулъя.

**Ц.Сандаг-Очир:** Яг цалин, тэтгэвэр, тэтгэмжийг ирэх жил яаж тооцож байгаа юм бэ? Ерөнхий хэлж болохгүй юм уу, нууц юм уу, эсвэл тодорхойгүй байгаа юм уу, ерөнхийдөө 1 нэмэх чигтэй байгаа юм уу гэдгийг нэг тодруулж өгөөч.

2-т, би энэ төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс одоо Төсвийн шинэчлэлийн хууль өргөн баригдчихсан байгаа. Ингээд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн дараа яригдах байх. Энэ өргөн баригдсан хуулийн үзэл баримтлалтай ер нь энэ өргөн баригдаж



орж ирсэн төсвийн хүрээний мэдэгдэл хэрхэн яаж нийцэж байгаа вэ? Нийцэл нь яаж хангагдаж байгаа вэ? Өр, өрийн тааз, төсвийн хүрээний мэдэгдэл, эдийн засгийн өсөлт, мөн цалин тэтгэврийг нэмэгдүүлэх, бараа бүтээгдэхүүн гол нэр төрлийн бараа бүтээгдэхүүний үнэ ханши, нүүрсний үнийг тооцоолсон байдал, энэ тэр гээд ингээд хэт өндрөөр эергээр төсөөлчихсөн байх юм. Үүнийг та бүхэн яаж үзэж байгаа вэ?

**Г.Тэмүүлэн:** Асуултад хариулъя. Хүрэлбаатар сайд хариулаад, Жавхаа сайд, Даваасамбуу дарга хариулна.

**Ч.Хүрэлбаатар:** Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. Бид нар 2024 оны жилийн төлөвлөгөөг өргөн мэдүүлчихсэн байж байгаа. Түүн дээрээ бид нар энэ бодлогоо аягүй тодорхой биччихсэн байж байгаа. Цалин болон тэтгэврийг цаашид инфляцын түвшинтэй уялдуулаад байнга нэмж байх, нэмнэ. Ер нь тэгээд инфляцын түвшинтэй уялдуулж цалин, тэтгэврийг нэмэхгүй болохоор эргээд эдийн засагтаа болон төрийн албан хаагчдынхаа орлогодоо сөрөг нөлөө үзүүлээд байгааг бид нар өөрсдөө мэдэж байгаа. Инфляцыг аль болохоор бага байлгахыг хичээх ёстой. Гэхдээ одоо юу гэдэг юм, цалин тэтгэврийг инфляц, үнийн өсөлт явагдаж байхад нэмэхгүй барьж үлдэх нь эргээд нийгмийн сөрөг үр дагавар ихтэй гэдгийг бид нар өнгөрсөн хугацаанд бас харлаа шүү дээ.

Тийм учраас ер нь цаашидаа Засгийн газрын бодлого бол инфляц болон цалинг, тэтгэвэр болон цалинг инфляцын түвшинтэй уялдуулж нэмэх ийм бодлоготой байгаа.

**Г.Тэмүүлэн:** Жавхлан сайд нэмж хариулъя.

**Б.Жавхлан:** Гишүүний асуултад нэмж хариулъя. Энэ зардлын зөрөө буюу нэмэгдэж гарах болох 2,5 их наяд маань ийм юм байгаа юм шүү. Би зүгээр дахиж

тодруулж ярья. Түүрүүн жосоохон дутуу хариулчих шиг боллоо. Бид нийт олж болох орлогоо эдийн засгийн өсөлттэйгөө уялдуулж тооцоод түүн дээрээ нэмэх нь тусгай шаардлагаараа бид нар алдагдлаа тооцчихоор, манай нийтийн эх үүсвэр гараад ирж байгаа юм. Өөрөөр хэлбэл энэ эх үүсвэрийнхээ хязгаарт манай зардал баригдана. Тэгэхээр энэ ирэх оны зардал энэ 2,5 их наядаар л өсөж болно шүү гэсэн цаад талын хязгаар юм байгаа юм. Үүнийг урсгал зардал дотроо бид нар аль аль руу нь эдийн засгийн ангиллаар нь шингээх вэ гэдэг бол саяын Хүрэлбаатар сайдын ярьсантай бас холбоотой. Цалинг нь хэдэн хувиар вэ? Нийгмийн даатгал жишээ нь татаас нэмэгдэнэ, хүн амын өсөлтөөрөө шууд механик нэмэгдэнэ, хүүхдийн мөнгөний тоо ч гэсэн механикаар нэмэгдэнэ. Гэх мэт урсгал зардлууд маань ингээд нэмэгдэнэ.

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хуульдаа бол бид нар дор хаяж инфляцын өсөлтөөр нэмнэ гээд ингээд оруулчхаж байгаа юм. Тэгэхээр энэ 2,5-ынхаа хязгаар дотроо эдгээр эдийн засгийн ангиллаараа бид төсвөө өргөн барихдаа төлөвлөлтөө хийгээд танилцуулна гэсэн үг. Одоо энд бол нууж хаах юм байхгүй. Одоо үүнийг төлөвлөхөд бол эрт, төсвийн хүрээгээ эхэлж батлуулж аваад ингээд бид 9 сар хүртэл өргөн барьтлаа энэ тооцооллуудаа, төлөвлөлтөө хийгээд тэгээд хугацаанд нь танилцуулна.

**Г.Тэмүүлэн:** Даваасамбуу дарга 7 номер.

**Д.Даваасамбуу:** Төсвийн өрийн асуудлаар, Засгийн газрын өөрийн асуудлаар Монгол Улсын Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс барьж байгаа зарчим бол арилжааны зээл буюу бондын зээлийг дахин санхүүжүүлэхдээ дор хаяж 20-30хувийг нь төсвийн боломжоо ашиглаж төлж байх нь зүйтэй гэсэн зөвлөмж өгсөн. Үүнийг Жавхлан сайдын ярилцлагаас болон танилцуулгаас үзэхэд хэрэгжүүлээд явж

байна гэж би ойлгосон. Ямар ч гэсэн 680 сая орчмыг бид төсвийнхөө боломжоос төллөө. Энэ хэмжээгээр, валютынх нь үнэлгээгээр би ярьж байна шүү. Валютынхаа үнэлгээгээр бондын маань зээлийн үлдэгдэл тодорхой хэмжээгээр багасаж яваа. Үнийн дүнгээрээ ханиийн 20 гаруй хувийн өсөлтөөрөө өсчихсөн байна лээ.

Дээрээс нь Засгийн газрын бас арай хөнгөлөлттэй зээлийн өсөлт байгаа. Энэ 2-ыг бид байж болох байх гэж бодож байгаа. Тэр учраас энэ арилжааны зээлээс одоогийн нөхцөлд шууд татгалзахаас өөр аргагүй. Дэлхийд мөнгөний үнэ ихэдсэн гэж үзэж байгаа.

Мөн өрийн дэлхий нийтийн үнэлдэг 5 үзүүлэлтээс 3-ыг нь бид дээд хэмжээнд нь буюу анхаарал нэн хандуулах шаардлагатай гэсэн хэмжээнд байгаа. Энэ маань өөрөө нийт өрийн хэмжээ. Тэгэхээр бид төсвийн шинэчлэлийн талаар өргөн барьж байгаа хууль эдгээрт юуны өмнө бас өрөө багасгах, цаашидаа энэ үнэтэй зээлээс татгалзах гэдэг тал дээрээ байх байх.

Дээрээс нь Засгийн газрын хэвлэл мэдээллээр өгч байгаа мэдээллээс үзэхэд ер нь төсвийг цаашидаа төсвийн гүйцэтгэл, шалгуур үзүүлэлтүүдэд ижилжүүлэх алхмыг хийнэ гэж ойлгож байгаа. Дэлхий нийтийн жишигийн дагуу салбарыг хариуцаж байгаа манай Эдийн засгийн яам маань бусад бүх яамдын төсвийн шалгуур үзүүлэлтүүдийг тогтоож, энэ үр дүнгээр нь ажлаа дүгнэх юм байна. Энэ маань өөрөө цаашидаа төсвийн хүрээний мэдэгдэл маань бас зардлын хязгаар, зардлыг гүйцэтгэлд суурилсан хувилбар луу орох нь. Энэ маань 2 жилийн өмнөөс эхэлсэн гэж би ойлгож байгаа. ЭМЯ дээр. Энэ жилээс Боловсролын яам дээр. Ингээд цаашидаа манай гол асуудлууд бас энэ юу гүйцэтгэлд суурилсан, шалгуур үзүүлэлтэд суурилсан төсвийн төлөвлөлт, төсвийн хяналт тогтох нь

гэдэг дээр бид энийг дэмжиж байгаа гэж ойлгож байгаа.

Дээрээс мэдээж манай эрсдэлтэй зүйл бол ихэнхдээ бид нарын тавьж та бүгдэд танилцуулсан материал, тэр нүүрсийг онцгойлон авч үзсэн байгаа. Бидний хүссэн хэмжээнд нүүрсээ гаргах уу, үгүй юү гэдэг дээр асар их ажиллагаа хэрэгтэй. Дээрээс нь бид өрсөлдөх чадвараа дээшлүүлэх шаардлагатай байх. 2022, 23, 24 оны Засгийн газрын ажлын үр дүн бол 1 дүгээрт, тэр төмөр замыг Гашиун сухайт, Тавантолгойг холбочихсон байх. Эрчим хүчний өнөөдрийн хэрэгцээг дор хаяж үйлдвэрлэлийг дор хаяж 20-30хувиар нэмэгдүүлсэн байх. Энэ л ажлын үр дүнгээр хэмждэг. Энэ маань өөрөө төсвийг тогтвортой болгох, төсвийн орлогыг нэмэгдүүлэхэд нэн чухал ач холбогдолтой гэж үзэж байгаа учраас энэ чиглэл рүү бид явна л гэж үзэж байгаа. Тийм учраас өрсөлдөх чадварыг дээшлүүлэх талаар ялангуяа нүүрсэн дээр онцгой анхаарч ажиллахыг бид санал болгож байгаа. Үнийн хувьд арай л ... /минут дуусав/

**Г.Тэмүүлэн:** Баярлалаа. Сандаг-Очир гишүүн болсон уу. Амартүвшин гишүүн асуулт асууна.

**Г.Амартүвшин:** Баярлалаа. Урсгал зардал нэмэгдэхээр тооцоолж байгаа юм байна. Тэгэхээр Жавхлан сайдын хариултаас сонсоход ямар ч байсан төрийн үйлчилгээ ялангуяа эрүүл мэндийн салбар, боловсролын салбарын цалин нэмэгдэнэ гэж ойлгож байгаа юм байна. Хүрэлбаатар сайдын хэлж байгаагаар бол инфляцтай уялдуулна гэж байна.

2 дугаарт, үүнийг тодруулъя. Түүнээс гадна хүүхдийн мөнгө бас тодорхой хэмжээгээр нийт дүн нь өсөх юм байна гэж ойлгосон. Тэгэхээр энийг бас тодруулж, яг хэдээр нэмэгдэхээр тооцоолж байгаа вэ? Ер нь яагаад энэ урсгал зардал нэмэгдэл талаар асуугаад

байна гэхээр яах вэ, инфляцын түвшин 6 хувь, 8 хувь гэж гаргасан байдаг. Өнөөдрийн байдлаар нэг 12 хувьтай байх шиг байна, тийм ээ. Тэгэхээр цалин нэмэгдэхээр тэр чинь тодорхой хэмжээгээр инфляцад нөлөөлнө гэж би онолоороо бол тэгж бодоод байгаа юм.

2 дугаарт, мөнгөний нийлүүлэлт, эм 2 чинь бас өсөөд л байгаа харагдаад байх юм. Тэгэхээр энэ дээрээс нь Дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт чинь бас нэлээн тийм өвдрөг төсөөлж байгаатай холбоотойгоор инфляцын 8 хувь чинь ер нь хэр бодитой юм бэ гэдэг дээр жоохон эргэлзээд байна л даа. Нөгөө талаас бодлогын хүү бол одоогоор өндөр байна, цааш Монголбанкны бодлогын хүү бол цаашидаа нэг удаа бас дахиад нэг өсөх байх гэсэн тийм хүлээлт байх шиг байна лээ, бизнесийнхний дунд. Тэгэхээр энэ чинь тодорхой хэмжээгээр бас эдийн засгийн өсөлтийг сааруулах арга хэмжээний нэг юм чинь инфляцын түвшинтэй чинь яаж уялдаж байгаа юм бэ гэдгийг би бас ойлгомоор байна.

Ер нь энэ 24 онд эдийн засгийн өсөлтөд хамгийн чухал нөлөөлдөг нэг юм нэг фактор нь болохоор гадаад шууд хөрөнгө оруулалт байгаа. Шууд гадаадын хөрөнгө оруулалтыг ер нь бодитоор хүлээгдэж байгаа хөрөнгө оруулалт юу байна? Ямар төслүүд ямар салбар дээр хөрөнгө оруулалт орж ирнэ гэсэн тийм төсөөлөл байгаа вэ?

Ханишийн талаар гэвэл одоогоор ханиш нэг сүүлийн 2, 3 сар тогтвортой буурч байна. Энэ бол манайд бол их эерэг. Цаашидаа ч гэсэн ханиш маань тэр чиглэлдээ үргэлжлээд буурна гэсэн хүлээлт байх шиг байна. Тэгэхээр 24 онд ханишны төсөөлөл гэж юм байдаггүй. Ер нь бол төсөв ярихад дандаа ханишийг ярихаас болгоомжлоод байдаг л даа. Гэхдээ нэг тодорхой хэмжээний бас тооцоолол байгаа л байх гэж бодож байна. Энэ талаар би хариулт аваад, тэгээд тодруулъя.

**Г.Тэмүүлэн:** Асуултад хэн хариулах вэ? Эдийн засагтай холбоотой асуудлыг Эдийн засаг, хөгжлийн сайд, Шадар сайд Хүрэлбаатар.

**Ч.Хүрэлбаатар:** Яг ханишийн тооцоолол ер нь ямар байх вэ гээд. Энэ төсвийн хүрээн дээр тооцоондоо бид нар ингээд 2024 онд экспорт нэмэгдэнэ. Нийт экспорт бол 14 тэрбум долларт хүрнэ. Үүнээс нийт импорт нэг 10 орчим, 10 тэрбум доллар тэгээд зөрөө нэг 4 тэрбум доллар, зөрөг гэж тооцож байгаа. Ер нь бол валютынхаа нөөцийг цаашидаа тасралтгүй нэмэгдүүлээд явах юм. Тэгэхээр ханиш дээр бол бид нар нэг тийм их эрс хөдөлгөөн бол гарахгүй гэж үзэж байгаа юм. Тэгэхээр ханишийг яг өнөөдөр сууж байгаа ирэх жилийн ханишийг төд гэж хэлэмгүй байна. Гэхдээ валютын нөөц нэмэгдэнэ, ханшаа бол бид нар үндсэндээ тогтворжуулаад авчихсан байгаа. Тийм учраас энэ хандлага бол 2024 ондоо үргэлжилнэ гэдэг ийм тооцоо бол оруулж ирсэн байгаа гэдгийг бол хэлье.

Ер нь гадаад худалдаа дээрээ бид нар нэлээд онцгой анхаарч байгаа. Үүнтэй холбогдуулаад түрүүн Даваасамбуу гуай ч ярьж байна. Одоо дэлхий нийтээрээ мөнгө үнэтэй болсон, хямдхан мөнгө олдоно гэж байхгүй. Тэр үед бид нар энэ эдийн засгийн өсөлтийг ер нь юугаар хангаж явах вэ гэдэг ийм чухал асуулт байгаа. Тэгэхээр ерөөсөө цаашидаа бол бидэнд мэдээж уул уурхай байна. Үүнээс гадна хувийн хэвшил, гадаадын хөрөнгө оруулалтыг хүчтэй дэмжиж байж, Монгол Улсын эдийн засгийн өсөлт гарч ирнэ.

Яг өнөөдөр бол Монгол Улс бол Гадаадын хөрөнгө оруулагчдыг анхаарлыг татсан хэвээрээ л байгаа. Хамгийн гол нь бид нар Гадаадын хөрөнгө оруулагчдад өмнөх алдаан дээрээс ямар сургамж авсан юм. Нөхцөл байдал сайжраад ирэнгүүт нь Гадаадын хөрөнгө оруулагч хэрэггүй гэдэг. Муудахаараа ороод ирээч гэдэг нэг ийм

сэтгэхүйгээсээ бид нар Монгол Улсын төр бол салах ёстой гэдэг ийм бодлогоор явж байгаа. Тэгээд гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих чиглэлээр, ер нь хөрөнгө оруулалтыг дэмжих чиглэлээр бид нар Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулж байна. Эдийн засгийн тогтвортой байдлыг хангаж байх, эдийн засгийн таатай орчныг бүрдүүлэх нөхцөлийг бүрдүүлэхээр хичээж чармай ажиллаж байна. Тэгэхээр ер нь л бодлогуудаа тогтвортой явуулж, эдийн засгийн үзүүлэлтүүдээ жил ирэх тутам л сайжруулж явахгүй бол зоонох мөнгө олоод ирэнгүүт нь цацдаг ч юм уу. Энэ нөхцөл байдал сайжраад эхлэнгүүтээ энэ гаднын хөрөнгө оруулалт хэрэггүй гэдэг нэг иймэрхүү сэтгэхүйнүүдээ л бид нар больчихмоор юм байна лээ.

Дээр нь янз бүрийн юмны хориг тавьдаг. Тухайлбал тэр нэг арьс шир хориглодог, экспортыг нь хориглодог, дээр нь хил рүү төмөр зам тавих нь хамаагүй илүү ашигтай байгаад байхад нэг зөрүүд хүүхэд шиг ингээд тэс хөндлөн төмөр зам барьдаг иймэрхүү тэнэглэлүүдээ л зогсоохвол Монгол Улсын эдийн засаг бол дорхноо шүү дээ. Жижиг эдийн засаг. Тэгэхээр цаашидаа иймэрхүү төрлийн тэнэглэлийг бид нар зогсоох ёстой гэж л бодож байгаа юм.

**Г.Тэмүүлэн:** Жавхлан сайд нэмж хариулъя. Жавхлан сайдын микрофоныг өгье.

**Б.Жавхлан:** Амартүвшин гишүүний асуултад нэмж хариулъя. Өнгөрсөн жил өдийд эдийн засгийн нөхцөл байдал маш амаргүй байсан, тодорхойгүй зүйлүүд маш их байлаа. Ялангуяа гадаад өрөөс хамааралтай нэлээдгүй эрсдэл, бүр гадаад өрийн зах зээл дээрээ Монгол Улс дефолт зарлах, дампуурлаа зарлах ч ийм өндөр эрсдэлтэй байсан. Энэ дээр ч бас нэлээдгүй бас тийм улс төрүүд явдаг л байсан. Ингээд бид 9, 10 сард төсөв өргөн барих үед энэ эрсдэлүүд мөн л

хэвээрээ байсан, маш хүнд байсан. Одоо өнгөрсөн намар л гэхэд төлөгдөх Чингис бондын үлдэгдэл 136 сая доллар, саяын бидний төлсөн ингээд 365 сая доллар, энэ жилийн мөн Засгийн газрын баталгаатай Хөгжлийн банкны бондууд гэх мэтчилэн маш хүнд нөхцөл байдлыг бид нар хүлээж байсан. Эдийн засаг маань 22 оны эцсээр яаж гарах нь хүлээж байгаа бид нар зорилгхүрч чадах уу, үгүй юү гээд.

Харин үүний төлөө бид гадаад өрийн хувьд хатуу чанга сахилга баттай явлаа. Энэ маш их хуримтлагдсан нүүрс болон бусад газрын баялагтай холбоотой далд эдийн засгийг ил болгосноор, арилжаагаа биржээр явуулдаг болгосноор, төрийн өмчийн томоохон компаниуд дээр онцгой дэглэм тогтоосноор, богино хугацаанд үр дүнгүүд гарч эхэлсэн, гарч эхэлсэн. Өнгөрсөн жилийн алдагдал 2,4 их наядаас 900 тэрбум боллоо. 2 тэрбум доллароос доошоо орно гэж байсан төв банкны валютын нөөц маань 3,4 тэрбум доллартой гарлаа. Эдгээр байдлаа ямар ч байсан 1 дүгээр улиралд бид хадгалж чадсан. 2 дугаар улиралд бас хадгалах гээд ингээд зүтгэж байна.

Ингээд нэг эхний хагас жилдээ нэг энэ тогтвортой байдлаа харж аваад, цаашидаа энэ маань ер нь хадгалагдах уу, үгүй юү гэдгийг бас баталгаажуулж аваад, ингээд эдийн засаг маань тогтворжих ийм төлөвтөө ороод ирвэл цалин пүнлүүгээ инфляцтай уялдуулж, мөн сая ковидын дайны энэ хэдэн 3 жилд өсгөж чадаагүй, хөндөж чадаагүй өрхийн орлого дэмждэг бусад төсвийн зардал гэсэн үг, нөгөө талаараа. Эд нарыгаа эргэж харах, ялангуяа хүүхдийн мөнгийг энэ дээр нэлээдгүй хүлээлттэй ийм байдаг орлого болсон.

Өнгөрсөн жил бид төсөв өргөн барьж байх үед ер нь гадаад өрийн энэ хүнд байдлаасаа болоод Олон улсын валютын санд очоод энэ хүүхдийн мөнгөө бид нар бүр 60, 50 хувь хүртлээ бууруулах



уу, эсвэл бүр ингээд дефолт зарлах уу гэдэг ийм л бид нар сонголт дээр байсан. Харин бид өөрсдөө ЗГ бие даасан ийм өрийн сахилга баттай менежменттэй явсны үр дүнд бидэнд өнөөдрийн энэ нэг явах боломж цухуйж ирж байна аа гэсэн үг.

Ингээд хагас жилээр дээр байдлуудаа баталгаажуулж аваад ингээд сүүлийн хагаст гэсэн үг. Бид хүүхдийн мөнгийг арай илүү хүрэлцээтэй байхаар хүсэлт гаргасан хүүхдүүд, гэр бүлүүдэд хүргэж болох ийм судалгаан дээрээ ажиллаж байна. Хэрвээ үнэхээр хүрсэн байгаа тогтворжилт маань сүүлийн хагас жилд ч гэсэн хадгалагдаад, экспортуудаа мөн цаашидаа бид ингэж дор хаяж энэ хэмжээндээ бариад, үнэ тогтвортой байх юм бол бид ийм боломж бидэнд бол бүрэн байгаа гэж ЗГ дээр бид судалж, ярилцаж байгаа.

**Г.Тэмүүлэн:** Амартүвшин гишүүн нэмж тодруулъя.

**Г.Амартүвшин:** Ямар ч байсан Гадаадын хөрөнгө оруулагчдад таалагдах нь аягүй чухал байгаа. Хүрэлбаатар сайдын хэлж байгаа бол, би бол зөв, тэгээд гол нь дэмжиж байна. Гол нь ярихаас илүү бид нар бас хийх хэрэгтэй л байна л даа. Жишээлбэл төмөр зам мухар төмөр зам байдаг тэгээд гол уул уурхайдаа бол ачааны машин биш төмөр замаар бараа бүтээгдэхүүн, хүдрээ экспортолмоор байдаг. Тэгэхээр ойрын үед энэ төмөр зам дээр ямар хөрөнгө оруулалт, ямар бодлого баримтлах вэ гэдгийг бас нэг тодруулчихмаар байна.

Жавхлан сайдаас нэг юм тодруулахад 24 онд ер нь цаашидаа нэг татварын бодлого, татварын тогтолцоон дээрээ нэг их өөрчлөлт орохгүй гэж ойлгоод байгаа шүү дээ, тийм ээ. Ингээд төсөв яригдахаар л НӨАТ-аа л оролдох гээд байдаг. Ер нь НӨАТ-аар оролдвол Шриланка шиг л болно шүү дээ. Тэгэхлээр энэ дээр

Жавхлан сайд бас аягүй тодорхой хариулж өгмөөр байна.

**Г.Тэмүүлэн:** Хүрэлбаатар сайд, дараа нь Жавхлан сайд.

**Ч.Хүрэлбаатар:** Энэ төмөр замын бодлого үнэхээр чухал байгаа юм. Тэгэхээр 1 дүгээрт нь, бид нар энэ Улаанбаатар төмөр замыг хүчин чадлыг нэмэгдүүлэх чиглэлээр тодорхой арга хэмжээ, аргууд авч хэрэгжүүлэн, Ханги боомтыг цаад талд нь байгаа Хятадын төмөр замтай холбох ажлуудыг энэ БНХАУ-ын талтай гэрээ хэлцлийн ажил нэлээд эрчимтэй шуурхай явж байгаа. 1955 оны төмөр замын гэрээндээ зөвхөн Замын-Үүдийн боомт байгаа шүү дээ. Түүнд Замын-Үүдээр гарч байгаа боомтыг л зохицуулдаг байсан бол үүн дээр нэмээд Ханги, Гашиунсухайт, Бичигт гэдэг ийм боомтууд нэмэгдэж байгаа. Тэгэхээр үндсэндээ нийтдээ 4 боомт болчихож байгаа учраас бас Хятадтай энэ чиглэлийн бодлогын гэрээ хэлцлүүдээ хийгээд, нэмээд явах юм.

Мөн хил хоорондын хилийн дэглэмтэй холбоотой бусад холбогдох дамжин тээвэрлэх зэрэг ийм гэрээнүүд дээр өөрчлөлт оруулахаар бол ажиллаж байгаа. Ерөнхий сайдын айлчлалын үеэр болж өгвөл зурчихаар ийм чиглэлээр бол ажиллаж байгаа. Гашиун сухайтын боомтыг бол тэр яг нэг дутаад байгаа нэг хэсэг байгаа шүү дээ. Нөгөө өндөрлөг зөрсөн, дутсан энэ хэсгийн зураг төслийн ажлыг хийлгээд тэрийг барих ажил гэдгийг үйлдэж байгаа. Тэгээд энийг бол энэ ондоо багтаагаад эхлүүлчих тийм зорилт тавиад ажиллаж байгаа. Гашиун сухайт холбогдоно.

Тэгээд дээр нь Бичигтийн боомтыг Бичигтийн төмөр зам бол концессоор нэг компани авчихсан үйл ажиллагаагаа явуулах гээд бэлтгэлээ хангаж байгаа гэж ойлгож байгаа. Тэгэх юм бол ингээд Улаанбаатар төмөр замынхаа хүчин чадал одоо 30 сая байгааг нэг 60 сая болгох ажлыг хийгээд



тэгээд боомтуудаа хилээр шууд, шууд янз бүрийн илүү зардалгүй, хурдхан шуурхай гаргадаг ийм болгочих юм бол бас хэрэгтэй гэсэн байдлаар ажиллаж байгаа.

*Шивээхүрэний нэг жоохон боомт газар дээр тэрийг эхлүүлчихмээр байгаа юм. Тэрийг эхлүүлчих юм бол манай нүүрсний экспорт нэг 10 хэдэн саяар нэмэгдчих юм. Тэгэхээр тэрийг бол ойрын үед эхлүүлэхээр ЗГ дээр мөн холбогдох шийдвэр гаргахаар бол яамдаас санал аваад явж байгаа гэдгийг хэлье.*

**Г.Тэмүүлэн:** *Жавхлант сайд.*

**Б.Жавхлан:** *Гишүүний асуултад хариулъя. Бид 2020 онд Татварын багц хуулиараа нэлээн тийм суурь эрх зүйн реформ хийчихсэн юм байгаа юм. Тийм учраас энэ татварын суурь хуулиуд, татварын тогтолцоо маань тогтвортой байх нь өөрөө энэ эдийн засгийн жигд өсөлт, эдийн засгийн макро тэнцвэрийг хадгалахад маш чухал үндсэн суурь хууль нь юм. Тийм учраас энийгээ ерөөсөө ойр ойрхон өөрчлөөд байх нь их зохимжгүй. Тийм учраас ойрын хугацаанд татварын тийм томоохон реформ хийх бол төлөвлөлт байхгүй. Нэгэнт хийчихсэн байгаа энэ реформынхоо үр дүнг дор хаяж 2 мөчлөг буюу нэг 8 жил бид нар харах хэрэгтэй гэж үзэж байгаа. Энэ өнгөрсөн реформ бол бас их муугүй реформ болсон. Одоо ч бас үр дүнгүүд нь сайн гарч байгаа гэж үзэж байна.*

*НӨАТ-ын хувьд сэдвийг та их зөв өнцгөөс хөндлөө. Баярлалаа. Энэ НӨАТ-ыг ч гэсэндээ ер нь бид нар ойр ойрхон хөндөх, ялангуяа нэг салбарын хууль орохоор л НӨАТ-ын хуулийг араас нь дагуулаад ороод ингээд хөнгөлөлт, чөлөөлөлт гээд байдаг юм. НӨАТ-ын хөнгөлөлт бол яг хөнгөлөлт тухайн салбарын хөнгөлөлт нь бол хөнгөлөлт болж чаддаггүй. Ялангуяа нэг бүтээгдэхүүн дагасан ийм хөнгөлөлт*

*бусдыгаа чирж унагаах, бусдынхаа өртгийг нэмэх, буцаагаад д ийм далд эдийн засгийн сүлжээг өдөөх ийм буруу хандлага руугаа явж ордог. Тийм учраас бид нэг 10 гаран жил арайхийж тогтоож ирсэн цаашаагаа нэлээд эерэг зөв хандлага руугаа явж байгаа энэ НӨАТ-ын орчноо бид хамгаалаад явах нь эдийн засагт маань их үр ашигтай. НӨАТ бол өөрөө нэгэнт төсвийн орлогын 25-30 хувийг бүрдүүлдэг хамгийн тогтвортой, уул уурхайгаас хамаарал багатай ийм уламжлалт томоохон төсвийн орлого бүрдүүлэлтийн хэсэг болсон байгаа. Тийм учраас та бас сая их зөв жишээ татлаа. Энэ Шриланка шүү дээ, 2019 онд бол улс төрчид нь нөгөө попролтой барьж дийлэхгүй 15 хувь байсан НӨАТ-гаа 8 болгож хаяад ингээд гадаад өрийнхөө дарамтад ороод тэрийгээ төлж чадахгүй дефолт зарлаад тэгээд гуравхан жилийн дараа 22 онд буцаагаад 15 хувь болгосон байдаг юм. Тэгэхээр энэ НӨАТ бол өөрөө их сонгодог татвар, 165 улсад энэ НӨАТ-ын ийм татварын системтэй. Эндээс бид 10-аас доош НӨАТ-ын хувьтай цөөхөн аравхан улсын нэгд ордог бид чинь, 2 хувийг нь буцаагаад өгчихдөг учраас 8 гэсэн үг. Манай 2 хөрш гэхэд л 15-аас дээш, Европ 15-аас дээш байх жишээтэй. Тийм учраас НӨАТ-аар ерөөсөө оролдож болохгүй ийм татвар болж ирсэн. Саяхан УАБЗ дээрээс ч хүртэл зөвлөмж гарсан. Зөвхөн НӨАТ төдийгүй татвараар нэгэнт саяхан хийгдсэн ийм суурь реформууд нь байж байна. Тийм учраас энэ татвараар ойр ойрхон оролдохгүй байхыг зөвлөсөн ийм зөвлөмж гарсан байгаа.*

**Г.Тэмүүлэн:** *Баделхан гишүүн асуулт асууна.*

**Х.Баделхан:** *Баярлалаа. Манай улсын эдийн засаг бол тогтворжиж байна, сайжирч байна. Энэ гадаад өр зээлийг бол хугацаанд төлж байна. Энэ бол сайн хэрэг. Үүнийг бол бид нар сайн ойлгож байгаа. Гэхдээ сая бид нар хөдөө яваад ирэхэд ер нь ирээдийн амьдрал бол*

маш хүнд байна, иргэдэд тусахгүй байна. Бид нар нэг үед энэ Оюутолгой, Тавантолгой гэсэн 2 том орд асар их нөөцтэй, ашиглалтад орвол амьдрал сайжирна л гэж ярьж байсан. Иргэдтэй уулзахад тэгж яриад явж байсан л даа. Өнөөдөр хоёулаа ашиглалтад орчихлоо. Тавантолгой ашиглалтад орчихлоо, Оюутолгой бол гүний уурхай нь ашиглалтад орчихлоо. Гэтэл иргэдийн амьдрал хэвээрээ л, хүнд хэвээрээ л байна. Тэгэхээр миний асуух гэж байгаа асуулт бол тэр Оюутолгойн гүний уурхай ашиглалтад орсноор ер нь ирэх жил улсад юу өгөх юм бэ, ер нь, өмнөх жилүүдтэй харьцуулахад, 1.

2 дахь нь энэ ордуудаасаа байгалийн баялгаасаа ер нь ирэх жил ард иргэдэд хүртэх юм байна уу, ер нь өгөөж байна уу, ард иргэдэд. Иргэд бол энийг л асуугаад байгаа. Үнэхээр эдийн засгийн өсөлт сайжирч байгаа юм бол ерөөсөө иргэдэд л тусахгүй байгаа. Сая зарим гишүүд асууж байна лээ. Цалин хөлс, тэтгэвэр тэтгэмж нэмэх үү гэж. Яах вэ инфляцтай уялдуулна л гэсэн ганцхан хариу өгч байгаа л даа. Гэхдээ тодорхой нэмэгдээд ер нь нэг хүнд ноогдох дотоодын нийт бүтээгдэхүүн ч юм уу ер нь иргэдийн амьдрал ирэх жил сайжрах уу гэсэн асуулт байна. Баярлалаа.

**Г.Тэмүүлэн:** Баделхан гишүүний асуултад Хүрэлбаатар сайд.

**Ч.Хүрэлбаатар:** Ер нь энэ 22 онд бол Монгол Улсын нийт өрхийн орлого бол 0,7 функтээр 0,7 хувиар буурсан байгаа юм. Үүнээс хөдөөгийн иргэдийн өрхийн бодит орлого бол 16 хувиар буурсан, бодит орлого шүү дээ. Инфляц би нэрлэснээр ирээгүй. Энэ чинь юу харуулж байгаа юм бэ гэхээр үндсэндээ энэ өнгөрсөн ковидын энэ хөл хориотой байх үед хэдийгээр хүүхдийн мөнгийг ингээд юу гэдэг юм, 20 мянга байсныг 100 мянга болгоод л, НДШ-ийг нь чөлөөлөөд л, хүн амын орлогын албан татварыг нь чөлөөлөлөөд л вакцинжуулаад л ийм арга хэмжээ хийгээд байсан ч гэсэн

цаана нь нөгөө хил хориотой болсноос холбоотой. Дээд талд нь энэ дэлхий нийтээр явагдаж байгаа үнийн өсөлт чинь ард иргэдийн амьдралд хүндээр нөлөө үзүүлж байгаа.

Дээр нь бид нар чинь бас яг энэ хил хориотой байх үед бол амаргүй хугацаанд ажилсан шүү дээ. Тэгээд бид нар юмаа дорхноо мартчихдаг ч бас энд нөлөөлөөд байх шиг байгаа юм. Ийм учраас эргээд энэ 24 оны жилийн төлөвлөгөөг та бүгдэд өргөн мэдүүлэхдээ ерөөсөө л ганцхан том зорилт тавьж байгаа юм. Өрхийн орлогыг нэмэгдүүлье гэдэг ийм зорилгын хүрээнд авч хэрэгжүүлэх тэр бүх арга хэмжээнүүдээ бид нар бүгдийг нь тавьсан. Төсвийнхөө тэнцлээ ч гэсэн тэр. Тэгэхээр ерөнхийдөө бид нар энэ дээрээс хараад ингээд улсаас юм өгөөд л байдаг, өгөөд л байдаг, тэгсэн мөртөө ингээд орлого буугаад байгаа энэ дээрээс бид нар ганцхан том дүгнэлт хийх ёстой. Ер нь энэ улс орны эдийн засгийн суурийг бол тэр бий болгодог хувийн хэвшилээ л бид нар сайн дэмжих ёстой. Тэдэнд янз бүрийн элдэв бусын хяналт шалгалт, хориг ийм юм байхгүй. Тэгээд Монгол Улс өөрөө тийм их үр ашиггүй юманд мөнгө цацаад байх хэмжээний тийм баян улс биш. Тэр тэс хөндлөн төмөр зам барьдаг, хэдэн их наядаар нь дээшээ мөнгө цутгадаг иймэрхүү л зүйлүүдээ болиод л яг цэвэр эдийн засгийн үр ашгаар нь эрэмбэлсэн ийм төслүүд рүү ингээд анхаараад явах нь бол илүү зөв өө гэдгийг харуулж байгаа юм.

Эрдэнэс тавантолгой дээр юу гэдэг юм, нүүрсээ биржээр зардаг, хил үнээр зардаг, ил тод байдлыг хангах зэрэг иймэрхүү арга хэмжээнүүдийг аваад хэрэгжүүлэхээр тэнд бол нөхцөл байдал өөрчлөгдөж байгаа, хэдхэн сарын дотор өөр болдгийг бид нар харж байгаа.

Оюутолгой дээр ч мөн ялгаа байхгүй. Би бол итгэлтэй байгаа. Орлого нь бол орж ирнэ. Орж ирдгээрээ орж

ирээд явах байх. Бид нар та бүгдэд энэ төсвийн хүрээний мэдэгдэлтэй холбоотойгоор зэсийн баяжмалын гарах хэмжээ, үнэ, эд нарыг бүгдийг нь төсөөллийг нь та бүгдэд хүргэсэн. Ер нь зэсийн гаргах баяжмалын хэмжээг бид нар 150 орчим мянгаар нэмэгдэнэ гэдэг ийм төсөөллийг авсан. Тэр компаниудынх нь жилийн төлөвлөгөөг авч байгаад манайхан тооцож оруулж ирсэн байгаа. Тэгэхээр гол өсөлтүүд бол 25, 26 оноос бол явагдах юм байна лээ. Гүний уурхайн. Наана нь тэр хонгил, эд нарыгаа хийх тэр ажлууд нь бол явагдан гэж бодож байгаа.

Ер нь Монгол Улсын эдийн засаг бол өөрөө жижигхэн. Бодлогоо зөв авч хэрэгжүүлээд, тууштай тогтвортой бодлогыг авч хэрэгжүүлээд, үндсэндээ яг макро эдийн засгийн авч явуулах ёстой бодлогуудаа авч явуулаад байвал энэ дорхноо сэргэнэ ээ л гэж би боддог. Тэгэхээр яах аргагүй энэ 22 онд, одоо ч гэсэн байдал амаргүй байгааг мэдэж байгаа. Би бас сая тойргоор яваад нэлээд уулзалтууд хийгээд ирсэн байгаа гэдгийг бас хэлье.

**Г.Тэмүүлэн:** Ганбаатар гишүүн асуулт асууя.

**С.Ганбаатар:** Өнгөрсөн жил эрх баригчид ярьж байхдаа инфляцын түвшнийг барина, тодорхой түвшинд нэг оронтой тоонд хүргэнэ гэж байсан. 2 дахин алдчихсан. Бодит тэр хүлээгдэж байсан түвшинээсээ бол ингээд 2 дахин өндөр байсан. 22 оны 6 сард бол 16,1 хувь байсан инфляц, 22 оны төгсгөл сүүлээр бол 13,2-той байна гэж үзэж байгаа. Энэ инфляцыг алдсанаас болж хүмүүсийн амьжиргаа дор орсон. Жишээ нь цалин, тэтгэврийн зээлийн хэмжээ 22 онд бол 9,2 их наяд болсон. Өмнөх жилийнхээсээ 49,1 хувиар өссөн. Хүмүүс үндсэндээ зээл, хүүд хүүлэгдэж эхэлсэн. Энэ дээр ганцхан төсвийн бодлого гэхээсээ илүү мөнгөний бодлого, хөдөлмөр эрхлэлтийн бодлого, үйлдвэрлэлийн бодлого гээд олон бодлого

орж байгаа ч гэсэндээ энэ дээр ямар нэгэн хариуцлага байгаа юу? Энэ дээр цаашид ямар арга хэмжээ авах вэ? 1 дүгээр асуулт.

2 дугаар асуулт, үүнээс чинь болоод л хөдөөгийн ард иргэдийн орлого 15,6 хувиар бодит өрхийн орлого унасан гэж байгаа юм шүү дээ. Энэ чинь бол тоо. Үүний цаана бол бүр их том шаналалууд явж байгаа, 1 дүгээр миний асуулт.

2 дугаар асуулт, 6 хувьд хүрэх юм байна. Энэ энэ жил бол ер нь бас аятайхан болох юм байна, 6 хувьд 5хувиар өснө гэж байгаа юм шүү, бас. Тэгэхээр энэ дээр бол гол нь нүүрсний экспорт, Оюутолгойн баяжмалын үйлдвэрлэл, зэс болон алтны агууламж нэмэгдэнэ. Ингээд ер нь сайхан болчихно л гэсэн байгаа. Энэ дээр сүүлийн хуудсан дээр манай өрийн хэмжээ В3 гээд В, В, В3 гэдэг рүү орчихсон юм байна. Энэ хөрөнгө оруулалтын өндөр эрсдэлтэй ангилалд ороод байна. Өгсөн зээлжих зэрэглэлийн дундаж нийлбэр дүнгээрээ ийм өндөр болчихлоо. Үүнээсээ гарахын тулд бид энэ дээр 4 зүйл заасан байна. Оюутолгой төслийн далд уурхайн бүтээн байгуулалт урагшилж байна л гэсэн. Үгүй ээ, энэ чинь олон жил шилний гаднаас чихэр долоолгож байна. Бид хэзээ ч хөрөнгө оруулалтын эсрэг биш, хөрөнгө оруулалт нэртэй спекуляц орж ирэх юм бол мөнгө хүүлэлт орж ирэх юм бол үүнийг ярина. Хөрөнгө оруулалтыг би дэмжинэ. Энэ зөв, хөрөнгө ор. Баялгаа өгөөд бид цаана нь асар их нөгөө 23 тэрбум доллар гэж сонсогдсон, бөөн юм болоод 2,3 тэрбум долларыг байхгүй болгосон гэж ярьсан 2,1 ч билүү. Бөөн юм болоод, бөөн зовлон болж байж. Энэ зүйлүүд энэ төсөв дээр хэр туссан бэ, яг аль үзүүлэлтээр гарч байгаа юм энэ нөгөө Дубайн гэрээг байхгүй болгосон, өр байхгүй болгосон гэдэг юм. Яг төсөв дээр аль тоон дээр байгаа юм бэ? Би үүнийг олж харахгүй байна.

2 дугаарт, миний энэ Оюутолгойтой холбож асууж байгаа зүйл гэвэл Оюутолгой орлогоо, ашгаа 30 жилээр график гаргачихсан байдаг. Манай Сангийн яаманд бол үүнийг өгдөг байх гэж бодож байна. Би бас сэмхэн нууцаар хараагүй байх. Эндээс үүдээд Оюутолгойгоос 24 онд тэд орж ирнэ, 25 онд тэд орж ирнэ, 26 онд тэд орж ирнэ гэж яг тодорхой заасан юмнууд байгаа юу?

Дараа нь би нэг сонирхолтой нэг юм эндээс уншихаад байна, гайхаад байна. Хуудас 38. Түүнчлэн 2021 оныг хүртэл байгуулагдаад буй гадаад зээлийн гэрээ хэлэлцээрийн хүрээнд авч ашиглаагүй зээлийн хэмжээ 13,5 их наяд төгрөгтэй тэнцэж байгаа. Үүнийгээ 3-5 жилийн хугацаанд авч ашиглах үүрэг хүлээсэн гээд нэг юм биччихсэн байна. Монгол Улсын Засгийн газрын зүгээс энэхүү ашиглаагүй зээлийн үлдэгдэлд 21 онд 16 орчим тэрбум төгрөгийн шимтгэл төлж байдаг. Үүнийг надад нэг дэлгэрүүлж өгөөч. Энэ ашиглагдаагүй зээл гэж яг юуг ярьж байна? Тэгээд энэ зээлийн үлдэгдэлтэй 16 орчим их наядыг тэрбум шүү, тэрбум төгрөг өгч байгаа юм байна гэсэн ийм миний 3 дахь асуулт болоод явчихлаа.

4 дэх асуулт, ... /минут дуусав/

**Г.Тэмүүлэн:** Жавхлан сайд хариулъя.

**Б.Жавхлан:** Ганбат гишүүний асуултад хариулъя. Гишүүн тэр зээлжих зэрэглэл агентлагуудын дүнг хаанаас харсан юм болов оо. Зөрөөтэй л хэлчих шиг болох юм. Манайх В тогтвортой, В3 тогтвортой гэдэг үнэлгээн дээр сүүлийн үндсэндээ 3 жил явж байна. Бид энэ зэрэглэл дээрээ өнгөрсөн 2 жилийн хугацаанд хамгаалах нь бид нарын хувьд хамгийн чухал байлаа. Манайтай ижил зэрэглэлтэй улсууд ихэнх нь унасан, өнгөрсөн жил ийм их өрийн эрсдэлтэй, дээрээс нь Хөгжлийн банк үндсэндээ дампуурчихсан. Төсвийн алдагдлууд

маань 3 жил ингээд дараалаад алдагдалтай явчихсан ийм хүнд үед бид зээлжих зэрэглэлээ амжилттай хамгаалж чадсан. Тэрийгээ эхний 1 дүгээр улиралд гадна талд илүү их баталгаажуулж чадсан. Ингэснээрээ зөвхөн Засгийн газрын өр төдийгүй хувийн хэвшлийнхний гадаад өрийг ч гэсэн тогтвортой байлгах, өгөөжийг нь нэмэгдүүлэхэд маш том амжилттай суурь нь болж өгсөн гэдгийг Засгийн газрынхаа өмнөөс баталгаатай танд хэлье.

Тэгээд энэ зээлжих зэрэглэлийг бид нар тогтвортой хамгаалж чадахад саяын таны дурддаг энэ Оюутолгойн хөрөнгө оруулалтыг бид гүний уурхайн, 12 жил хүлээлээ шүү дээ. Үүндээ хүрч чадсан нь маш том бас ийм суурь нөлөө болсон. Энэ нь бусад гаднын ирээдүйд орж ирэх хөрөнгө оруулагч нарт маш том эерэг мессеж, индикатор болж байгаа юм шүү. Хэдийгээр энэ 23 онд чамлахаар чанга атга. Энэ далд уурхайн дөнгөж эхний жил нь юм байгаа юм. Дөнгөж эхний жил нь, бид 12 жил дөнгөж нийт баялгийнхаа Оюутолгойн 20 хувь дээр нь л зүгээр сунгавчлах ажил хийсэн. Одоо үндсэн 80 хувийнхаа орд руугаа бид нар орж эхэлж байгаа юм. Энэ жилдээ ингээд нэг 50 тэрбумаар өмнөх жилтэй харьцуулах юм бол нөгөө орлого Оюутолгойгоос нэмэгдэнэ. Энэ нийтдээ нэг 700 орчим болох байх. Ингээд шат дараатай нэмэгдэнэ. Та энийг бол хамгийн айн мэдэх хүн. Оргил үед, оргил үе нь 28 оноос эхлэх юм. Олборлолт нь нэг 1 сая 500 орчим болоод, тэр үед хани ямар байх нь вэ? Орлого 2 дахин нэмэгдэх ёстой, биет хэмжээ бол 2 дахин нэмэгдчихнэ. Ингээд нэг тогтвортой 5-6 жил энэ оргил үе нь явах юм байгаа юм. Ийм л бид хүлээлттэй байгаа.

Төсвийн хүрээний мэдэгдэл бид нар ирэх жилийнхээ төсвийн хүрээний мэдэгдэл дараагийн 2 жилийнх нь төсөөллийг оруулж ирж байгаа юм. Түүнээс 20, 30 жилийн асуудал бол



өнөөдөр төсөв дээр бол бид нар ярих боломжгүй. Тухайн уурхай дээр бол төсөөллүүд бол ийм байгаа гэсэн үг.

**Г.Тэмүүлэн:** Хүрэлбаатар сайд.

**Ч.Хүрэлбаатар:** Энэ Оюутолгойн 2 дугаар үе шатын үйлдвэрлэл, баяжмалын үйлдвэрлэл дээр бол хамгийн гол нь агууламж нэмэгдэх юм. Тухайлбал зэсийн агуулга 23 онд 24,4 хувь, 24,4 хувь. Ирэх жил энэ нь 28,2 болж нэмэгдэнэ. 25 онд 28,6 хувь болно. 26 онд 30,3 хувь болно. Тэгэхээр ирэх жилүүдэд Оюутолгойн тэр доошоогоо гүний уурхайнууд ажиллаад эхлэхээр гаргаж байгаа нүүрснийх нь агууламжууд нь ингээд бараг хэд үү, 6 функтээр нэмэгдээд явагдахаар ийм харагдаж байгаа юм.

Дээр нь алтны агууламж 23 онд 7,3, 24 онд энэ 7,9 болж нэмэгдэнэ, 2025 онд 11,7 хувь болж нэмэгдэх юм. Ингэхээр бид нар энэ Оюутолгойн бол юу гэдэг юм, гаргаж байгаа бүтээгдэхүүнүүдийн агууламж нэмэгдэнэ ээ гэдэг нь бид нар т бас энэ их чухал их сайн мэдээ болж байгаа гэдгийг хэлье.

Хөрөнгө оруулалтуудыг бол бид нар Ганбаатар гишүүн дэмжиж байгаад баяртай байна. Ер нь бид нар хар аа, хөрөнгө оруулалтаа нэмэхгүйгээр гаднын хөрөнгө оруулалтыг татаж энэ даяарчлалын нэг хэсэг болж хувирахгүй бол бид нар энэ 20 дугаар зуунд үлдэх нь байна шүү, ер нь. Тийм учраас жоохон шуурхай харж, урагшаа харж, ирээдүйг харж хөдлөх нь хөдөлж байж л бид нар Монгол Улс хөгжинө. Тэгэхгүй бол өөрсдийнхөө хөгжлийг чамлаад бусад орны хөгжлийг магтаад яриад байвал яриад л байна. Хамгийн гол нь үүнтэй холбогдуулаад энэ хөгжил дэвшлийг ноу хау, технологи, энэ бүгдийг бол оруулж ирэхэд тэр хөрөнгө оруулагч нар л оруулж ирж хамтарч ажиллах болов уу л гэж бодож байгаа. Тийм учраас бид нар хөрөнгө оруулалтаа дэмжиж явах нь зөв өө. Баярлаж байна.

**Г.Тэмүүлэн:** Нэмээд Жавхаа сайд тодруулах уу, Жавхаа сайд хариулчихъя.

**Б.Жавхлан:** Гишүүн уучлаарай, би нэг зүйл нь дутуу орхисон байна шүү. Ашиглагдаагүй зээлийн үлдэгдэл гээд. Өнөөдрийг хүртэл ялангуяа олон талт хөгжлийн институтүүдээс авсан, мөн 2 талтуудаас авсан гээд нийт өмнө нь хийгдчихсэн гэрээнүүдийн ашиглагдаагүй үлдэгдэл нь бол 13,5 их наяд мөн. Энэ дээр бид нар жил болгон 0,5 хувийн шимтгэл төлдөг нь ч бас гэрээгээрээ хүлээсэн үүрэг юм байгаа юм. Тухайлбал энд ямар зээлүүд байдаг вэ гэхээр жишээ нь юуны газрын тосны үйлдвэр юм байна. Бид нар 1 тэрбум долларын гэрээтэй, дөнгөж ашиглалт нь 100 гаран сая доллартой байж байх жишээтэй. Үлдэгдэл дээр нь ийм шимтгэл төлж байгаа. Тийм. Тэгэхээр бид нар ашиглалтаа сайжруулах, яаралтай ашиглалтад оруулж, эргэж төлөгдөх эх үүсвэрүүдээ энэ төслүүдээс нь өөрсдөөс нь гаргуулах тэрийг цаг хугацаагаар нь наашлуулах. Энэ л их чухал байгаа. Тийм.

**Г.Тэмүүлэн:** Ганбаатар гишүүн нэмж тодруулъя.

**С.Ганбаатар:** Би түрүүн тэр зээлжих зэрэглэлийг бол хуудас 43, 44-өөс харж хэлсэн байгаа шүү. Тэгээд дээр нь нэмээд яах вэ, нөгөө Оюутолгойн гэрээ, Дубайн гэрээний энэ хортой хүч бидний хохироосон заалтуудыг хүчингүй болголоо, байхгүй болголоо, цуцаллаа гээд л өнгөрсөн өвөлжингөө шуугьсан санагдах юм. 23 тэрбум доллар билүү тоог нь санахгүй байна, 2,3 тэрбум долларын өрийг тэглэсэн гээд л ярьж байсан. Энэ зүйлүүд манай энэ төсвийн тоон дээр хэр тусаж байгаа вэ? Засгийн газрын өрийн нийт хэмжээ өнөөгийн үнэ цэнээр 39 их наяд 276 тэрбум төгрөг гэж байна. 25 онд бол 43 их наяд болоод 47 их наяд болоод ингээд явчхаж байгаа юм 26 онд. Тэгэхээр энэ дээр яаж тусгалаа олсон бэ? Энэ ерөөсөө ямар ч нөлөөгүй байгаа юу? Тэр хувийнх



гэдгээрээ явдгаараа нөгөө Оюутолгой чинь хувийнх гээд явж байгаа, түүгээрээ явчхаж байгаа юу. Засгийн газрын өрөнд хэр нөлөөлж байгаа вэ?

2 дугаар миний асуулт, үнэнхүү ...  
/минут дуусав/

**Г.Тэмүүлэн:** Жавхлан сайд хариулах уу? Жавхлан сайд.

**Б.Жавхлан:** Уучлаарай. Тэр бас орхигдчихсон байна. Энэ одоо яг байгаа бид нар өрийн удирдлагын тухай хуулиар бол Засгийн газрын өрөнд орж тооцохгүй шүү дээ. Тооцдоггүй, тийм. Улсынхаа нийт өрөн дотор л ороод явж байгаа. Гэхдээ энэ тооцоолол болохоос биш Монгол Улсын бид өрийн эрсдэлийг тооцохдоо бид нар бүтнээр нь тооцож л харна, бүтнээр нь тооцож л харна. Тэгээд Төв банкны валютын нөөц гэдэг бол Засгийн газрын нөөц биш. Энэ Монгол Улсын валютын нөөц. Тийм учраас энийгээ бид нар ингэж тооцож явалгүй яах вэ.

Нэрлэсэн үнэ, ирээдүйн үнэ цэн бас л эрсдэлийн л тооцооллын л аргачлал шүү дээ. Бид нар аль болох эрсдэлтэй өндөр дүнгээр нь тооцоолж, ДНБ-нд эзлэх хувь хэмжээгээ тусгай шаардлагынхаа хүрээнд яг Засгийн газрын хувьд 60 хувь дотроо маш сайн тогтвортой ингээд хадгалаад явж байгаа. Тийм.

**Г.Тэмүүлэн:** Батжаргал гишүүн асуулт асууя.

**Ж.Батжаргал:** Төсвийн хүрээний мэдэгдэл төсөөлөл орж ирж байна. Тэгэхээр энэ бол эдийн засаг, төсвийн үндсэн үзүүлэлтүүдийн зохистой түвшиний харьцаа юм. Тэгээд үүгээрээ дамжуулж бид нар эдийн засгийн өсөлт, амьжиргааны түвшинээ зөв авч явах тухай л бодлого л доо угаасаа. Тийм учраас үүн дээр бид нэлээн няхуур хандах ёстой гэж ингэж ойлгодог. Орох орлого талаа бид мэдээж нэлээн нарийн

тооцсон байх. Би дан дамаа биет хэмжээснүүдийн өсөлтийг нэлээн сайн зөв тооцсон байлгүй гэж ойлгоод байна л даа.

Оюутолгойн баяжмалаас бид нар 150 орчим мянган тонн гэж байгаа юм уу, энэ чинь? Тийм нэмэгдэхээр ийм л төсөөлөл харагдаж байгаа юм шиг байгаа юм. Үнийн асуудал нь нэлээн юутай.

Нүүрсэн дээрээ бид 36,5-тай явсан улсууд 50 гэхээр зэрэг 14 орчим сая тоннын өсөлттэй гээд ингээд авч. Тэгэхээр үүнийг нэлээн их бодитой дүгнэж байж бид нарын өнөө орлого тал буюу буцаагаад зарцуулах хөрөнгийн маань хэмжээний асуудал бол зөв гарч ирэх ёстой гэж. Үүнийгээ нэлээн нарийсгаж үзсэн байх гэж хараад байна.

Зардал талаа бид төсөөлж байна. Төсөөлөхдөө бас өсөлтийнхөө хувийг нэгэнтээ тооцсон бол тэр дотор энэ иргэдийн амьдралын чанарыг сайжруулахтай холбоотой зардлуудын ерөнхий төсөөлөл харагдах ёстой. Тийм учраас цалин, тэтгэвэр, тэтгэмжийн өсөлтийг бид ер нь хэд гэж багцаалдаж байгаа юм, 1.

2 дугаарт, дан ганц цалин тэтгэвэр 2-оор амьдралыг авч явахгүй нь ойлгомжтой. Үнэхээрийн л баялаг бүтээлтийг дэмжье гэж байгаа бол энэ хувийн хэвшил гэдэг юм уу баялаг бүтээгчдийг дэмжих хөрөнгийн талынхаа асуудлыг дотоодоосоо яаж хэдүүлээ дайчилна гэж харж энд ямар хэмжээний баримжаатай хөрөнгө юмнуудыг төсөөлж байгаа вэ гэдэг асуудал байгаад байна л даа. Жишээ нь бид нар 23 он дээр 220 хэдэн тэрбум төгрөг зээлийн хүүгийн зөрөөнд гээд тавьж байгаа явдал чинь бол баялаг бүтээгчдийг дэмжиж байгаа, зээлийг их наядад хүргэх гээд л зүтгэж яваа улс шүү дээ. Яг үүн шиг ер нь ийм эх үүсвэр талыг дэмжсэн юм хэдий хэмжээгээр тусаж орсон юм бэ гэдэг асуудал.

Дараагийн нэг асуумаар байгаа зүйл байгаа юм. Энэ өр, тэнцлийн алдагдал 2-ыг бид их зөв харах ёстой. Дан дамаа тэнцлийн алдагдлыг бол бид 1,8-тай байх ёстой юмыг 1,5-тай ЗГ маань оруулж ирээд, Байнгын хороон дээр 1,4-тэй болгож бид 23 оны төсвөө баталсан. Тэгэхээр үүнийг Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзэлдэг хуулийн хувиар тооцож тавиад баймгүй байна, бодитой тавимаар байна. 24 оны төсөөллийг бид хэд гэж үзэх юм? Миний л ойлгож байгаагаар жоохон хариуцлагатай явцаая, бас энэ нэг орлого, зарлагынхаа тэнцэл юмнуудыг зөв барьж, энэ улс орны хөгжлийн юмыг харж явъя гэж байгаа бол 0,8-аас нэг их давуулж тоо тавимгүй санагдаад байгаа. 24 оны тэнцлийн алдагдлыг.

Өр. Өрийн удирдлагын тухай хуулийн коэффициентээр бид тавьчхаад байгаа улс байхгүй юу. Бидэнд байж байгаа тоогоор 8,5 тэрбум долларын Засгийн газрын өртэй тухай ярьдаг. Дотоодын нийт бүтээгдэхүүний 60 хувьтай тэнцэж болно гэж хэлээд 39 их наядаар аваачаад тавьчхаад байгаа явдал чинь нийгмийг тэр чигт нь буруу мэдээлэлжүүлээд болж өгөхгүй байгаа юм. Одоо байгаа өр чинь яг хэд юм? 24 онд зайлшгүй энэ хөгжлийн хэрэгцээ шаардлага дээрээ уялдуулаад, зохицуулалт дээрээ уялдуулаад хэдий хэмжээний юм нэмж авах юм гэдэг юмаа тодорхой болгож тавимаар байгаа юм. Тэгж байж 56 хувь гэдэг юм уу 58 ... /минут дуусав/

**Г.Тэмүүлэн:** Жавхлан сайд асуултад харуулъя.

**Б.Жавхлан:** Тийм, Батжаргал гишүүний хэлж байгаа санаа зовж байгаа өнцөгтэй би ер нь бол санал нийлж байна. Гэхдээ бид нарын нөгөө нэг төсвөө төлөвлөдөг зарчим, төсвийн хүрээний мэдэгдлээ баталдаг зарчим маань ер нь бол хязгаараа батлах ёстой. Одоо саяын таны асуудаг цалин, зээлийн хүү, энэ өрийн хэмжээнүүд бол бид нар

байгаа төсвийн шаардлагын хуулиуд дээрээ нарийн заачихсан. Жишээ нь тэр өрийн үлдэгдэл бол тэр хязгаараараа л явна. Өөрөөр хэлбэл бид нар энэ хязгаарыг хэтрүүлж болохгүй ээ л гэсэн үг. Хэтрүүлж болохгүй ээ гэсэн үг. 23 оныхоо төсвийг хийхдээ эндээ баригдаж орж ирэх л ёстой. Түүнээс эндээс хэтрүүлж болохгүй гэсэн үг. Цалин ч гэсэндээ хэдэн хувиар хэд орчим нэмэгдэхийг бас хэлэхэд арай эрт байна. Одоо бид нар наад энэ асуулт яг нөгөө төсөв өргөн бариад, төсвийнхөө зардлыг задалж ярихад л яригдах боломжтой ийм тоонууд.

Ямар ч байсан түрүүн таны асуудаг тэр зээлийн хүүгээр дамжуулж баялаг бүтээгчдийг дэмжих бодлого бол үргэлжилнэ. Ялангуяа хөдөө аж ахуйн салбар, үндэсний аюулгүй байдал, мөн ирэх жил сая ковидын үед эхлүүлсэн ажлын байрыг дэмжих зээлийн гарсан тэр зээлүүдийн сүүлийн жил нь. Тэгэхээр тэр энэ бодлого бол ингээд дуустлаа тууштай ингээд түүхэн үүргээ гүйцэтгээд явна. Тэгээд ямар ч байсан энэ оныхоосоо бодлогын хэмжээнд багасахгүй. Одоо удахгүй энэ чиглэлийн урсгал зардал авч явдаг төсвийн ерөнхийлөн захирагч нар, сайд нар маань саналуудаа оруулж ирнэ. Тэндээс бид 2,5 их наяддаа яаж нэмэгдлүүдийг нь багтаах вэ? Энэ жил гээд байхдаа хэвээр нь барих вэ гээд. Энэ бүх зүйлүүд яг төсвийн өмнөх өргөн барихын өмнөх, төлөвлөлтийн үед илүү их тодорхой болоод явна. Баярлалаа.

**Г.Тэмүүлэн:** Батжаргал гишүүн нэмж тодруулъя.

**Ж.Батжаргал:** Тийм, хязгаар гэдгийг бол мэдээд байгаа. Гэхдээ хязгаар гэдэг бол зүгээр коэффициентын нийлбэр биш л дээ. Ямар хэмжээний юмнуудын барагцааны хэлбэрийн дүн ийм гарах юм гэдэг юу ерөнхий төсөөлөл юм. Одоо бид нарт энэ 7 хоног өнгөрөөд, дараагийн 7 хоногт дахиад иргэдтэйгээ очоод уулзана. Бид төсвийн хүрээний мэдэгдлээ

ярьж байгаа. Зардал маань 10 хэдэн хувиар өсгөж байгаа, тэр дотор ер нь энэ амьжиргаа дэмжихтэй холбоотой юм нь нэг тэдэн функц нь байгаа юм шүү гээд ярих л ёстой шүү дээ, бид. Тийм учраас тоо тодорхой байх ёстой. Үүнийг илүү задалмаар байна, мэдээлээ задалж өгмөөр байна. Тэгж байж бид нар энэ талынхаа асуудлыг зөв яримаар байна. 2024 оны хөгжлийн төлөвлөгөө үүнтэйгээ ерөнхий багцаагаараа бол анзаарагдаж уягдах ёстой. Гэтэл мухар төмөр замуудын Хангийн замын гүйцэтгэл 20 хувьтай л гэж байна, холболтын ажил. Юуны Гашиун сухайтынх нь.

**Г.Тэмүүлэн:** Жавхлан сайд хариулъя.

**Б.Жавхлан:** Тийм. Тэгэхээр төсвийн хүрээний мэдэгдлийг бол бид хуулийн хүрээнд ерөөсөө энэ 9 макро тоон дээрээ л оруулж ирдэг юм байгаа юм. Энэ бол дан яг хязгаар, яг цаг хугацааны хувьд ч гэсэн одоо бид нар энийг задалж ярьж тайлагнах ийм боломжгүй. Яамнууд төсвийн эргэлтэд захирагч нарт ч гэсэндээ тэд одоо ч төлөвлөж амжаагүй байгаа. Задалж төлөвлөж амжаагүй байгаа. 6, 7 сараас л эхний төлөвлөлтүүд гарч ирдэг, 6, 7 сараас л эхэлж Сангийн яаман дээр эхний 24 оны саналууд ирнэ. Тэр үед илүү задлах боломжтой, ярих.

Харин төсвийн хүрээний мэдэгдлүүдээ ингэж хязгааруудаа батлуулж аваад энэ хүрээндээ харин иргэн яаж төлөвлөх вэ гэдэг дараагийн ажилдаа төсвийн ерөнхийлөн захирагч нар маань ороод ингээд явна. Тийм.

**Г.Тэмүүлэн:** Болсон уу, Батжаргал гишүүн. Батсуурь гишүүн.

**Ж.Батсуурь:** Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 25, 26 оны төсвийн хязгаар, төсөөлөл орж ирж байна. Тэгээд сая бас Сангийн сайд ч хэллээ. Энэ

бол хязгаар гэж, нарийвчилж бид нар энэ хүрээнд төсвийн хүрээний мэдэгдлээ баталчихвал нарийн юу руугаа орох байх. Тэгэхдээ бодлогын чанартай хэд хэдэн зүйлийг асууя гэж бодож байна.

Энэ орон нутагт явж байхад бүх л тойрог дээр адилхан байгаа байх. Мэдээж тэтгэврийн шинэчлэл цалин, хөлсийг инфляцтай тохируулж нэмэгдэнэ ээ гэж. Тэгээд энэ дотроо тэтгэвэр дээр нэг ийм зүйл л яригдаад байгаа юм. Жишээлэх юм бол, 32-40 жил багш хийсэн хүний цалин 500 мянга, эмч хийсэн хүний цалин 500 мянга, ажил хийж байгаагүй юм уу ингээд орон гаран нийгмийн даатгалаа төлж, төлөөгүй байсан хүмүүсийнх бас 500 мянга. Тэгэхээр энэ зөрөөг бүр бодлогын хувьд шинэчилж өгөөч ээ гэж маш олон хүмүүс хэлэх юм, Эдийн засгийн сайд аа. Тийм болохоор эндээ барьж байгаа бодлого юу байна вэ гэсэн ийм нэг асуулт байна.

Дараа нь энэ, Та сая хэллээ. Боомтын хөгжил хил рүү гарах төмөр зам авто замыг хурдан хугацаанд барьж байгуулах гэж. Энэ зүүн бүсийн босоо тэнхлэгийн төмөр замын асуудал ер нь хэзээ эхэлж, хэзээ дуусах вэ гэсэн ийм төсөөлөлтэй байдаг вэ. Бичигтийн боомтын энэ ашиглалт хэзээ бүрэн дүүрэн явж, эдийн засгийн үр өгөөжөө өгч эхлэх вэ гэсэн энэ асуултад та бүхэн нэг хариу өгөөч гэсэн.

Нөгөө зүйл бол энэ 19, 20 онд эхлүүлсэн дутуу барилгууд байна. Зарим нь ингээд яамнууд дээр хар дансанд орчихсон. Тэгээд ингээд хаягдчихсан. Бид нарын ярьдгаар бол нөгөө сонгуулийн жил жаахан амсуулаад, амсуулаад тавьчихсан. Тэгээд энийг нэг бүрэн дуусгамаар байна, бүр нэг бодлого гаргаж. Тэгэхгүй бол эхнээсээ суурь нь байхгүй болоод дуусаад, тэгээд бүр нөгөө тэмээн дээр ямаа, ямаан дээр юуны гарз ч билээ ийм байдлаар. Тэгэхээр энийг энэ төсвийн энд байгаа бүр эдийн засгийн том бодлогоддоо нэг оруулж өгөөч ээ гэсэн ийм нэг зүйл байгаа юм.

Дээр нь би сая бол 19, 20 оныхыг ярилаа. 21, 22 онд, 23 онд бол бид нар шинэ хөрөнгө оруулалт тавиагүй. 21, 22 оны тендерт шалгарсан компаниуд бол ковидын үлдэгдэл шавхруун дээр бол нэлээд бас үйл тамаа барж байна гэсэн ийм саналууд та бүхэн дээр ч гэсэн ирж байгаа байх. Яагаад вэ гэхээр тендерт гарсан компаниуд дөнгөж шалгарчхаад энэ сонгон шалгаруулалтад орчхоод байтал арматурын үнэ 2 дахин, цементийн үнэ, тэгээд хил гаалийн татвар гээд, тэгсэн мөртөө хийж яагаад нэг дуусгачихсан. Тэгэхээр энэ үнийн өсөлтийн зөрөөг ер нь өгнө гэж байгаа юу, өгөхгүй гэж байгаа юу. Өгвөл ямар түвшинд өгөх гэж байгаа вэ гэсэн энэ тал дээр ийм хэдэн багц асуудлуудаар мэдээлэл авъя гэж бодож байна.

Бусад асуух асуулт бол бусад гишүүдийнхтэй давхардсан гэж байгаа юм.

Дараагийн хамгийн сүүлийн нэг зүйл бол энэ зээлийн хүүгийн асуудлыг хувийн хэвшлийнхэн бол ерөөсөө зээлийн хүүг л бууруулаад бид нарт нэг ийм нэг олон дахин дарамтгүй болгоод өгчихвөл бид нар ер нь төр засгаас айхтар олон зүйлийг нэхээд байхгүйгээр бас нэг энэ амьдралаа тэжээгээд, татвар мөнгөө төлөөд ингээд явчих юм аа. Тэгэхээр энэ ойрын он жилүүдэд ер нь зээлийн хүүг минимум хэд, максимум хэд энэ 2 аль интервалд бид нар бизнесээ төсөөлж байх вэ гэсэн ийм асуудалд бас хариу авъя аа гэж ингэж бодож байна. Баярлалаа.

**Г.Тэмүүлэн:** Жавхлан сайд асуултад хариулъя.

**Б.Жавхлан:** Батсуурь гишүүний асуултад хариулъя. 23 онд үнийн өсөлтийг 303 тэрбум төгрөгөөр буюу эцсийн байдлаар аудитлагдаад энэ үнэхээр бодит үнийн өсөлт мөн байна аа гээд. Ингээд Барилга, хот байгуулалтын яам дээрээс ирсэн энэ жагсаалтыг бид бүрэн оруулсан, 23 онд бүрэн оруулсан

гэсэн үг. Тийм. Одоо орчхоод байгаа. Одоогоор гүйцэтгэл нь 152 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй гарчхаад байгаа юм байна. Оны эцэс рүү үнийн өсөлт энэ бас харьцангуй гүйцэтгэл сайтай яваад ингээд энэ зарцуулагдаад гарчих болов уу гэж бодож байна.

23 оны төсөв хийж байхад энэний цаана үлдсэн нэг хэсэг байгаа тийм ээ. Өөрөөр хэлбэл 23 оны төсвийг 9 сард, 11 сар, 10 сарын 1-нд өргөн барихад аудитлагдаж амжаагүй байсан хэсэг нэлээн үлдсэн. Тэр ингээд процесс аудитаар шат шатдаа ингээд явж байгаа. Төсвийг өргөн барих үед энэ нь хэдий хэмжээний орж ирэх юм, одоо урьдчилж бол хэлэх боломжгүй байна. Ер нь ноднин яригдаж байсан нийт хэмжээ нь 600 гаруй тэрбум яригдаж байсан шүү дээ. Тийм тэндээс өмнө 303 нь орж ирсэн гэсэн үг. Тийм, ийм байна.

Тэр зээлийн хүү энэ тэр бол яг зах зээлийнхээ л жамаар л тогтоно шүү дээ. Зээлийн хүүг. Та санаж байгаа байх, 2019 онд эдийн засаг маань нэлээн тогтворжоод гадаад өр зээлийн асуудал ч байж нэлээн цэгцрээд, сахилга баттай ингэж явж ирж байхад зээлийн дундаж хүү 12 хувь руу аягүй ойртож ирсэн шүү дээ. Сарын 1 хувь руу маш ойртож ирсэн байхгүй юу. Төв банкны бодлогын хүү 6 хувь болчихсон ирсэн. Одоо ингээд эдийн засгийн нөхцөл байдал хүндэрсэн. Ингээд ийм мөнгөний хатуу бодлого, төсвийн ч гэсэндээ маш хэмнэлттэй ийм бодлогын үед зээлийн хүү бол 2 дахин нэмэгдсэн бодлогын хүүгээ дагаад.

Ингэж байж бид эдийн засгийн хэт уналт, одоо бол эдийн засгийн хэт халалт энэ бүхнээсээ ялангуяа төсвийн бодлого, мөнгөний бодлого 2-ыг маш уялдуулж ингэж явах хэрэгтэй. 22 онд бол энэ 2 бодлого бол хамгийн классик хэлбэрээрээ л уялдсан. Мөнгөний хатуу бодлого тууштай явлаа. Бид төсвийнхөө үндсэн тэнцлийг алдагдлыг 3 дахин үндсэндээ бууруулж ингэж чадлаа. Тэгж байж үнийн хэт өсөлтийг бас тогтвортой хэмжээнд бага ч гэсэн



буурах ийм төлөв рүү шилжүүлсэн байгаа.

Харин цаашидаа нэг жоохон гарч ирж байгаа энэ боломжоо бид энийгээ дагаад төсвийнхөө зардлыг өсгөөд, мөнгөний бодлогынхоо яг эсрэгээр нь ингэж хөдлөөд буцаад нэг жоохон тогтворжиж авч байгаа энэ эдийн засгаа буцаагаад бид нар баллачхаж болохгүй. Тэгэхээр алхмаа тааруулж ингэж явах хэрэгтэй. Өөрөөр хэлбэл төсөв, мөнгөний бодлого уялдаад үнэхээр мөнгөний бодлого зүйл хэрэг, тэр орон зай бий болох оны сүүл рүү ч юм уу ирэх онд ч юм уу тэрнээс хойш л зээлийн хүү буурах ийм эерэг хүлээлэлтүүд л байх хэрэгтэй байх. Тэрнээс биш наана нь бол бид нар төсвийн бодлого дээр үндэслэж зээлийн хүү буурна тэгнэ, ингэнэ гэдэг тийм амлалт бол байхгүй шүү дээ. Тийм ээ. Баярлалаа.

**Г.Тэмүүлэн:** Болсон уу, Батсуурь гишүүн. Төмөр зам, нэвтрүүлэх хүчин чадал. Хүрэлбаатар сайд хариулъя.

**Ч.Хүрэлбаатар:** Би бас сая тойргоор явж сонгогчидтойгоо уулзсан. Яг саяын хэлж байгаа тэр юу гэдэг юм 36 жил, 42 жил ажиллаад авч байгаа тэтгэврийн хэмжээ нь түүнээс бага нөхцөлөөр ажиллаж байгаад нөгөө нэмэгдээд 500000-ыг авч байгаатай бараг адилхан авч байгаа. Үүнийг тэгээд салгаж бас тэгш, тэр өмнө нь байсан тэр шударга байдлыг тогтоож өгөөч ээ гэдэг ийм зүйл асууж байгаа. Ер нь тэр 22 оны 2 дугаар сард нэмэгдсэн түүн дээр бол алдаа гарсныг бол бид нар бүгдээрээ мэдэж байгаа. Тэгээд алдлаа гээд асуугаад байлтай биш. Энэ саяын хэлдэг энэ зарчмуудыг бол бид нар ялгааг гаргаж оруулж өгөхөөс өөр арга байхгүй. Тэр чиглэлээр Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам ажиллаж байгаа гэж бодож байна. Энэ талаар бас Засгийн газар дээр яригдсан гэдгийг хэлье.

Зүүн босоо төмөр зам ерөнхийдөө энэ Европ бол Оросын холбооны улсад

хаалттай болчихлоо шүү дээ. Тэгээд зөвхөн энэ жилдээ ч биш, ирэх 10, 20 жил хаалттай байх нь ойлгомжстой. Тэгэхээр тэр зүүн босоо төмөр замаар бол ачаа тээвэрлэлт нэмэгдэх юм байна лээ, 2 талдаа. Хятад улсаас ч тэр, Монгол Улсаас 2 тийшээгээ ч тэр, Хятадаас Оросын холбооны улс руу явах ачаа нэмэгдэх юм байна лээ. Тэгэхээр нөгөө Эрээн цавын боомт байгаа. Тэгэхээр Эрээн цав буюу тэр Саблёвскийн боомтыг 1 дүгээрт нь олон улсынх болгох ёстой. Одоо Эрээн цаваас Чойбалсан хүртэлх энэ төмөр зам бол Улаанбаатар төмөр замын мэдлийнх. Тэгэхээр Улаанбаатар төмөр замаас энийг бол хүчин чадлыг нь нэмэгдүүлэх, Чойбалсанаас Бичигтийг бол төр бол концесс зарлаад нэг компани авсан гэж байгаа, тэр нь хийгдээд явж байгаа. Тэгэхээр ингээд энэ цогцоороо шинэчлэгдэж ер нь явна л гэсэн ийм л бодлого бол байгаа. Тэгээд Бичигтийнхийг би ЗТЯ-наасаа хэзээ ашиглалтад орохыг нь тодруулъя. Нэг 2 жил л болов уу гэж бодож байна, 2 жил. Тэгээд сайн барьж амжвал нэг жилийн дотор барьж болдгийг бас харуулчихсан шүү дээ, Хангийн боомт. Тэгэхээр 1, 2 жилдээ энэ болчих болов уу л гэсэн бодолтой байна. Яг Эрээнцэв Чойбалсан чиглэлийнхэн яг тодорхой мэдээлэл өгөөгүй, ОХУ-ын ЗГ тодорхой шийдвэр гаргаад бас явж байгаа юм байна лээ.

**Г.Тэмүүлэн:** Батсуурь гишүүн нэмж тодруулъя.

**Ж.Батсуурь:** Яг энийг ярьсантай холбогдуулаад би харин Хүрэлбаатар сайдын чихэнд нь юу яачихъя. Бичигтийн боомтоос 100-140км-т тэрбум тонны нөөцтэй хүрэн нүүрс байна. Одоо бараг 6-7 компани хөрс хуулалтаа хийчихсэн. Тэгээд энийг уул нь төрөөс жоохон дэмжээд яг ингээд бодлогыг нь наашлуулаад өгчих юм бол экспортын орлого Монгол Улсад үлэмж хэмжээгээр нэмэгдэх ийм боломж байна. Тэгэхдээ хамгийн гол нь төмөр замыг хүлээвэл удахаар байна, хил рүү даацын зам тавих



юм бол маш олон тонн сая тонноороо гарах ийм боломжууд байна. Тийм учраас яг Бичигтийн боомтын өөрийн ачаалал даах чадварыг хурдан сайжруулах тухай тал дээр та онцгой анхаарч өгөөч. Бичигтийн боомтоос төмөр зам хүлээхгүйгээр 100-140км-т байгаа тэр тэрбум тонны нөөцтэй бараг арваад тэр компанийн экспортыг дэмжих тал дээр ... /минут дуусав/

**Г.Тэмүүлэн:** Санал хэллээ гэж ойлголоо.

Гишүүд асуулт асууж дууслаа.

Миний хувьд бас нэг ганц 2 тодруулах асуудлууд байна, байгаа. Гишүүд саналаа хэлнэ.

1 дүгээрт, яах вэ, зүгээр Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс бас дүгнэлт гарсан. Бид бүхний хувьд ч бас гол анхаарах асуудал. Ер нь яах вэ зүгээр төсөв өөрөө тэлэх, зарлага өөрөө их гарах, төсөв өөрөө томрох тусам нэг талдаа бид нар энэ импортыг дэмжээд байдаг валютын ханшийг унагах ч гэдэг юм уу, инфляц өсгөхөд өөрөө төсөв өөрөө бас асар их нөлөөлтэй болчихоод байгаа юм. Тэгэхээр яах вэ, зүгээр гол асуудал бол яг энэ орлого нэмэгдэж байгаа, түүхий эдийн хани нэмэгдэж байгаа энэ цаг үеэ ашиглаад нэг төсвөө алдагдалгүй батлах, гадаад зээл хүүгийнхээ дарамтаас салах энэ шаардлага байна л гэдэг хэн хүнгүй бүгдээрээ бас ойлгож байгаа. Тэгээд энэ бодлого чиглэл дээр бол бүгдээрээ байгаа. Тэгэхээр энэ дээр уялдуулаад нэг зүйлийг би тодруулж асуух гээд байгаа юм.

Засгийн газрын өрийн хэмжээг хуулийн хязгаар бол уг угаасаа хуулиараа 60 хүртэл байгаад байгаа. Гэтэл та бүхэн маань танилцуулга дээр орж ирэхдээ Засгийн газрын өр 2024 онд 49 хувьтай тэнцэх төсөөлөлтэй байна гэж авч байгаа юм, 49 хувьтай тэнцэх төсөөлөлтэй байна аа гээд. 49 хувиар тооцоод үзэх юм бол өөрөө энэ 24 онд 32

их наяд байхаар төсөөлөл байгаад байгаа юм. Тэгэхээр жишээ нь одоо яг төсвийн хүрээний мэдэгдэл дээр 24 онд өргөн барьсан төсөл дээр 32 их наяд биш 39,2 их наяд болж орж ирж байгаа юм. Тэгэхээр бид нар заавал ч үгүй энэ Засгийн газрын өрийн хэмжээг хуулийнх нь дээд хэмжээ нь буюу 60 хувь хүртэл нэмэгдүүлэх ямар шалтгаан байгаад байгаа юм бэ. Болбол 50 өрийнхөө хувь хэмжээ хязгаарыг нь доошлуулаад ингээд багасгаад явах боломж байхгүй юм уу, энэ дээр ямар асуудал байна вэ гэдэг асуудал.

2-т, төсвийн хөрөнгө оруулалтын зардлын дээд хязгаарыг 2024 онд 5,8 их наяд төгрөг байхаар тусгасан байгаа. Тэгэхээр Засгийн газраас өргөн баригдсан Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө энэ 2 уялдах ёстой. Тэгэхээр 1 талдаа энэ 2 уялдсан байгаа байх гэж ойлгож байгаа. Тэгэхээр бүх шаардлагатай хөрөнгө оруулалтын санхүүжилтийг 2024 оны төсөөлөлд тусгасан гэж ойлгох уу. Энэ 5,8-даа багтаж тусгасан гэж ойлгох уу? Яг 24 оны төлөвлөгөө, төсвийн хүрээний мэдэгдэл 2 бол ан цав ялгаа зөрөөгүй хоорондоо нийцсэн байх гэж, нийцсэн байх ёстой, зарчмын хувьд.

3 дугаарх нь, тэнцвэржүүлсэн орлогыг 21,2 их наяд төгрөг төвлөрнө гэж тооцсон байгаад байгаа юм. Тэгэхээр Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн дагуу тооцсон энэ гол нэр төрлийн бүтээгдэхүүнийг тэнцвэржүүлсэн үнэ тооцсон аргачлал маань яг ямар байсан юм бэ? Энэ тал дээр та бас нэг дэлгэрэнгүй тайлбар өгөөч. Тэнцвэржүүлсэн орлогод тооцогдох энэ гол нэр төрлийн бүтээгдэхүүнийг зэс, нүүрс гэж тооцсон байгаад байгаа. Өргөн баригдсан төсвийн хүрээний мэдэгдэл, төслийн хүрээнд. Тэгэхээр үүнээс өөр голлох нэр төрлийн бүтээгдэхүүн буюу орлогын 3 хувьд бүр хүрсэн өөр нэр төрлийн уул уурхайн бүтээгдэхүүн байгаа юу. Эсвэл зөвхөн энэ хоёроороо тооцсон уу, эсвэл

орлогын 3 хувьд хүрсэн өөр нэр төрлийн уул уурхайн бүтээгдэхүүн бас байгаа эсэх талаар тайлбар өгөөч гэх гэсэн юм. Энэ 3 асуулт дээр нэг тайлбар авах гэсэн юм.

*Жавхлан сайд хариулах уу, та. Жавхлан сайд.*

**Б.Жавхлан:** 1 дүгээрт, өрийн асуудал тийм ээ. Өрийн асуудал бол сая таны хэлдэг тоонууд бол яг зөв. Гэхдээ бид төсвийн хүрээний мэдэгдэл дээр хязгаараа л танилцуулах, хязгаараа батлуулж авах л ийм бид төлөвлөлтийн хуультай. Тийм учраас эндээс хэтрүүлж болохгүй шүү. Үүнийхээ дагуу бид жил бүр ингээд бууруулаад явах ёстой шүү гэдэг энэ төлөвлөгөөнийхөө дагуу явж байна. Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Өрийн удирдлагын тухай хууль гээд, дунд хугацааны стратеги гээд энэ гол 3 бичиг баримт дээрээ бид өрийг зээл авахаар бол ямар зарчмаар авах вэ, юуг нь яаж төлөх вэ, 1 дүгээр ээлжид хамгийн өндөр эрсдэлтэй явдаг, хамгийн өндөр зардалтай явдаг, эдийн засгийн үр өгөөжгүй явж ирсэн энэ бондуудынхаа өрийг төлж барагдуулах хэрэгтэй. Үнэхээр яг шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд байгаа Их Хурлаар батлуулж авсан хөрөнгө оруулалтын жагсаалтаасаа санхүүжүүлэхээр бэлэн бол олон талт хөгжлийн институцүүдээсээ үнэхээр яг тэд бүтэц санхүүжүүлдэг, урт хугацааны хүү багатай, эдийн засгийн өгөөжтэй, төлбөрийн тэнцэлд эерэг үр дүн авчрахаар ийм шалгуур хангасан зээлүүдээ авч ашиглах ийм шалгууруудаараа нөгөө 60 хувь дотроо бариад л явах юм байгаа юм.

Ирэх жил ТЭЗҮ нь бэлэн болоод санхүүжүүлэх шаардлагатай ийм зүйлүүд гарч ирэхийг үгүйсгэхгүй. Яг таны сая харсан тэр 32 их наяд бол одоо байгаа төслүүдийнхээ хүрээнд төслүүд нэмэхгүй, төлөвлөсөн төлбөрүүдээ хийгээд явбал гэсэн ийм тооцоолол байгаа юм. Тийм учраас яг хязгаараараа л өргөн барьсан байгаа юм.

5,8 их наяд гэдэг бол нийт хөрөнгө оруулалтын тоо гэдгийг бол та сайн мэдэж байгаа. Энэ дээр бол гадаад зээл, тусламж, дамжиж байгаа хөрөнгө оруулалтууд, шилжиж байгаа хөрөнгө оруулалтууд, шинэ хөрөнгө оруулалтууд гээд. Энэ дээр хөгжлийн төлөвлөгөөнд шинэ хөрөнгө оруулалтын дүн 24 онд санхүүжих нь 1,3 их наяд. Үүнийг төсөвт тусгахын тулд Төсвийн хууль, хэмнэлтийн хууль, шалгуур үзүүлэлтүүдийг хангасны үндсэн дээр бид энэ жилийн гүйцэтгэл маань бас сүүлийн хагас жил 3 дугаар улиралд яаж явах нь вэ, төсөв яг өргөн барих үед ямархуу гүйцэтгэлтэй байх нь вэ гээд олон зүйлээс бас хамаарах юм байгаа юм. Тийм учраас яг ирэх оныхоо төсвийг өргөн барихад аль болох нийцүүлж бид төсөв яг хөгжлийн бодлого төлөвлөлтийнхөө гаргасан хязгаар дотроо мөн бид барьж ажиллана.

Үнүүдийн хувьд иүүд бид тэнд учруулсан үнийг томъёогоор авчихдагийг та мэдэж байгаа. Тийм ээ, өнгөрсөн 19 жил дараагийн 3 жилийн төсөөлөл гээд энэ жилийн гүйцэтгэл гээд ингээд дунджаар нь авчихдаг. Нийт орлогын маань 3%-аас дээш давах буюу стратегийн бүтээгдэхүүнүүдэд яг уламжлалт бүтцээрээ л явж байгаа, шинэ төрөл бол ирэх жилд байхгүй.

**Г.Тэмүүлэн:** Хүрэлбаатар сайд нэмж хариулах уу, та.

**Ч.Хүрэлбаатар:** Төсвийн хүрээ, 24 оны жилийн төлөвлөгөө 2 бол макро бүх тоогоороо нийлж байгаа. Ер нь л нийцүүлэхээр хичээж нэлээд ажилласан. Нийцүүлээд л оруулж ирсэн байгаа, нийцэж байгаа.

**Г.Тэмүүлэн:** Тэгэхээр зэс, нүүрсээр тооцож байгаа. Зэс дотор жишээ нь алтны агууламж хэдээр тооцсон бол? Хэдэн тонноор юу гэдэг юм алт гарна гэж тооцсон байгаа бол. Энэ дээр нэг тодруулж авах гэсэн юм.

**Б.Жавхлан:** Баяжмал доторх бүтцүүдийг бол бид тэгж тооцдоггүй байгаа. УУЯ-наас ирдэг, яг салгасан тооцооллоор. Дээрээс нь алтыг бол ялангуяа бид Монголбанкнаас ирсэн тооцооллоор Эдийн засгийн хөгжлийн яам, манай 2 шууд аваад явдаг юм байгаа юм.

**Г.Тэмүүлэн:** Тийм. Би бас Эрдэнэс, Оюутолгойгоос ч тэр Уул уурхайн яамнаас мэдээллүүд авсан юм. Тэгээд энэ дээр уул уурхай бол 24 онд, 25 онд, 26 онд алтны олборлолт буюу алтных нь агууламж нь өөрөө нэмэгдэнэ. 24 онд алт өөрөө 6,9 тонн зөвхөн Оюутолгойгоос, 25 онд 15,6 тонн, 26 онд 10,7 тонн гэж гарч ирээд байгаа юм. Тэгэхээр би зүгээр гол хүсээд байгаа зүйл бол зэс, нүүрсээс гадна тогтвортой байдлын тухай хуулиараа энэ тэнцвэржүүлсэн орлогодоо тооцогдох ёстой орлого маань энэ алтны орлого болчихоод байна. Энэ маань өөрөө бодитоор орлогын 3 хувьд хүрсэн. Бас нэг 3 дахь одоо юу гэдэг юм уул уурхайн нэр төрлийн бүтээгдэхүүн болоод байна. Энэ тооцогдоогүй асуудал болчихоод байгаа юм биш үү гэдэг нэг асуудал байгаад байгаа юм. Тэгэхээр үүн дээр бид нар бас нэг анхаарах зүйтэй байна гэж хараад байгаа юм. Тэгэхээр энэ дээр та хэд бас нарийвчилсан тодорхой мэдээлэл байхгүй байгаа юу?

2-т, бас дахиад түрүүн гишүүд хэд хэдэн гишүүд ч бас нэг тодорхойлж хэлсэн. Төсвийн зардлыг 12,3 хувиар өсгөөд төсөөлсөн гээд энд биччихсэн байгаад байгаа. Яг жигд гишүүд асуугаад байгаа зүйл энэ юу гэдэг юм зардлын өсөлтийн чинь 12,3 хувь зардлынхаа анги зүйл тус бүр дээр жигд хуваарилаад тооцчихсон юм уу, ямар бодлого баримталчихсан юм бэ, эсвэл доторх задаргаа нь юу байгаад байгаа юм бэ гэдэг асуудлыг асуугаад байгаа байхгүй юу. Тэгэхээр үнэхээр юу гэдэг юм тодорхой зүгээр ерөнхий тоймоор бид нар авчихсан гэж байгаа бол бид нар үүнийг заавал ингэж нэг ийм тодорхой

12,3 хувиар ч гэдэг юм уу өсгөж тооцож төсвийн зардлыг өсгөж, энэ чинь алдагдалтай батлаад байх шаардлага байна уу гэдэг асуудал байгаад байгаа байхгүй юу. Нарийвчилсан тодорхой юм нь одоо уг нь гарчихсан байх ёстой гэж хараад байгаа юм. Энэ 12,3 хувийг гаргахын тулд.

Энэ 2 асуудлыг нэмж тодруулж асууя.

Эхлээд Хүрэлбаатар сайд.

**Ч.Хүрэлбаатар:** Алтыг бол 24 онд 20 тонноор тооцчихсон байгаа юм. Урьд өмнөхтэйгөө адилхан. Тэгэхээр 20 тонн дээр тооцчихоор нөгөө 3 хувьдаа хүрэхгүй болчихоод байгаа юм л даа тэгээд. Тийм учраас тэрийг бол тооцоогүй байгаа.

Дараагийн зүйл төсвийн алдагдлыг өшөө дахиад сайжруулаад явчхаж болох уу гээд. Ер нь ингээд одоо яг үзэхээр бид бүгд ч гэсэн тойргоор явсан, төрийн албан хаагчдын цалин нэмэх, бараг 2 жил ч нэмэгдээгүй байгаа. Тэтгэврийн түрүүн ярьдаг бас зөрөөг гаргаж нэмэх ёстой, олон жил ажилласан мөртөө 42 жил ажиллачхаад түүнээс хамаагүй бага төлсөн хүмүүстэй адилхан хэмжээний тэтгэвэр авч байна гээд иргэд, ахмадуудын хувьд яриад байгаа энэ бол үнэн шүү дээ. Үгүй ээ ер нь бодитой шүү дээ. Ингэж бас болохгүй шүү дээ. Тэгэхээр тэрийг гаргах зэрэг ... /минут дуусав/

**Г.Тэмүүлэн:** Хүрэлбаатар сайдад нэмье.

**Ч.Хүрэлбаатар:** Тэр энэ зөрөөг гаргахад зардал орно. Дээр нь хүүхдийн мөнгийг 100 хувь олгоно гэсэн ийм чиглэлээр ЗГ бас ажиллаж байгаа. Тэгээд энэ бүх тооцоонуудаа эргэж үзэхээр бас тэр төсвийн алдагдлыг бас тэгж хамаагүй ирсэн буулгагч боломж бол их бага л харагдаад л тэгээд л оруулж ирж байгаа. Баярлалаа.

**Г.Тэмүүлэн:** Жавхаа сайд нэмээд тайлбарлая.

**Б.Жавхлан:** Байнгын хорооны даргын асуултад нэмж хариулъя. Бидэнд үлдэж байгаа зардлын маань орон зай л гэж ингэж хараарай. Түүнээс биш бид нар нийт зарлагаа тооцох юм бол нэмэгдэх зардал маань 2,5 их наяд биш 3,4 их наяд болж ирж байгаа юм, бүр 12,5 биш энэ чинь бүр бараг 25, 6 хувь болж ирж байгаа байхгүй юу. Үнийн өсөлт нь. Түүн дотор жишээ нь юу орж ирж байгаа юм бэ гэхээр төрийн албаны хаагчдын цалин хөлс. Бид нар ингээд тооцоолол, зүгээр тооцоолол шүү, зүгээр суурь тооцоолол хийхэд 1,5 их наядар нэмэгдэж байгаа юм. Төвлөрлийг сааруулах арга хэмжээ энэ мөнгөн урамшуулал 30 тэрбум 1 удаагийн тэтгэмжийн зардал ингээд хүн амынхаа өсөлтөөрөө 70 тэрбум, ахмадын тэтгэвэр ингээд хүн амын өсөлт болон сая хэлж байгаа тэр тохируулгуудыг хийхэд 253 тэрбум, Эрүүл мэндийн даатгалын сангийн зарлагын өсөлт хүн амынхаа өсөлтөөр 81 тэрбум, нийгмийн даатгалын шинэ хуулийн нөлөөлөл энэ яригдаж байгаа шинэ хуулийн нөлөөлөл дээр тэндээс дангаараа гэхэд л 894 тэрбум төгрөгийн нэмэлт гарч ирнэ. Бусад арга хэмжээ, энэ хүүгийн зардал түүрүүн Батжаргал гишүүн асуусан түүн дээр гэхэд л нэг ойролцоогоор 244 орчим гарч байна. Гадаад зээлийн тусламж ирэх жилийн сонгуулийн зардал, ирэх жил олимпын зардал эдгээр дээр гэхэд л 460 тэрбум, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ энэ жил бас нэмэгдэхээр ийм шаардлага зайлиггүй шаардлага гарч ирж байна. Энэ дээр 74,5 тэрбум гээд ингээд зайлиггүй хойтон нэмэгдэх зардлуудыг бодох юм бол энэ чинь 3 их наяд 397 тэрбум төгрөг байхгүй юу. Гэтэл энэ 2,5 гэж байгаа юм чинь хаанаас гарч ирж байгаа вэ гэхээр боломжит нийт орлогоо тооцоод, тэгээд тусгай шаардлагын дагуу энэ боломжит алдагдлаа тулгаж тавихаар нийт эх үүсвэр маань ингэж гараад, түүнд гарах зардал маань энд

тулаад л ирнэ. Үүнийг өнгөрсөн жилийнхтэй харьцуулахад 2,5 их наядар нэмэгдэж байгаа юм. Цаана нь дахиад бидэнд 900 тэрбум төгрөгийн эх үүсвэр бас шаардлагатай гэсэн үг байхгүй юу. Жишээ нь саяын бид энэ дор хаяж нэмэгдэх ёстой энэ урсгалуудыг санхүүжүүлэхэд. Тэгээд төсөв өргөн барьтал энэ дээр бид ЗГ дахиад ажиллана л гэсэн үг. Тийм учраас бид нар эцсийн байдлаар энэ тооцоолуудыг задалж ярих хугацаа нь болоогүй байна.

Төсвийн эрх хүлэн захирагч нараас яам болгон энэ дээр ажиллаж байна. Тийм, ийм л юм байгаа юм. Тийм учраас төсвийн зардлыг эндээсээ л яаж өсгөхгүй, тэртээ тэргүй эх үүсвэр байхгүй болж ирж байгаа юм. Нэмэлт эх үүсвэр эндээс илүү байхгүй юм чинь. Үүндээ саяынхаа зардлуудыг шингээх л асуудал ярихаас болохоос биш энэ зардлыг дахиад бууруулна гэдэг ойлголт бол тийм ямар ч боломжгүй асуудал болж ирж байгаа юм.

**Г.Тэмүүлэн:** Баярлалаа. Дахиад нэг зүйл нэг тодруулах зүйл нь голлох нэр төрлийн бүтээгдэхүүнд орчихсон байгаа нүүрс дээр. Уучлаарай нүүрсэн дээр, нүүрсний тоо хэмжээ болоод нэгжийн үнийг ер нь яг яаж тооцсон юм бэ? Яг нэг тонн нүүрсэнд ноогдох төсвийн орлогын хэмжээг та хэд бас хэлээд өгөөч гэх гээд байгаа юм. Тэгэхээр яг ирэх оныхоо тооцоолол, төсөөллийг бид нар бас яг нүүрсэн дээр яаж тооцсон юм бол гэдэг бодитой бас тоонууд хэрэгтэй байгаад байгаа юм.

Хүрлээ сайд хариулах уу.

**Ч.Хүрэлбаатар:** 24 онд бид нар тэр 50 сая тонн нүүрс гаргана гэж тооцож байгаа. Дундажлаад авч байгаа үнэ 139 доллароор тооцсон. Тэр татварын орлогуудыг нь Сангийн яам ярих байх.

**Г.Тэмүүлэн:** Тэгвэл Жавхаа сайд татварын орлогыг нь та. Нүүрсэн дээр



50 сая тонн нүүрс экспортолно гэж тооцож байгаа нэгж үнийг нь 139 доллароор дунджаар тооцож байгаа гээд, үүнээс орох нэг тонн нүүрсэнд ногдох төсвийн орлогын хэмжээ. 2 номер. Тэлмүүн.

Төсвийн бодлогын газрын дарга Санжаа. 2 номер. Болохгүй бол 5 номер дээр үзэх үү. 5.

Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж Байнгын хорооны даргын асуултад хариулъя. 2024 онд бол нүүрсний хэмжээг 50 сая тонн, дундаж үнийг бол 140 доллар байна гэж төсөөлөл бол Эдийн засгийн хөгжлийн яамнаас танилцуулж орж байсан. Үүний дагуу бол бид татварын орлого бол тооцсон байгаа. 2024 онд нийтдээ 3,3 их наяд төгрөг зөвхөн нүүрстэй холбоотойгоор орлого бүрэлдэх юм байна гэж үзэж байна. Энэ дээр бол мэдээж хэрэг Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, НӨАТ-ын орлого, дээрээс нь Хувь хүний орлогын албан татвар гээд холбоотой бүх орлогуудыг нь бол нэгдсэн байдлаар бол тооцсон, мөн АМНАТ-ын орлого бас тооцогдсон байгаа.

**Г.Тэмүүлэн:** Сая нэгдэж нэгжид тооцох нь хэд гэсэн бэ? Нэг тонн нүүрсэнд ногдох төсвийн орлогын хэмжээг нүүрсэн дээр.

**М.Санжаадорж:** 60 тэрбум гарч байна.

**Г.Тэмүүлэн:** 60 тэрбум. Ойлголоо. Баярлалаа.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Хуулийн төсөлтэй холбогдуулж санал хэлэх гишүүд байна уу. Үг хэлэх гишүүд байна уу. Батжаргал гишүүнээр тасалъя.

**Ж.Батжаргал:** Хүрээний мэдэгдэл, төсөөллөө үзэл баримтлалынх нь хувьд бид дэмжих ёстой. Бид амаргүй цаг хугацааг даван туулж байгаа. Гэхдээ бас би боломжтой давж байгаа гэж ингэж ойлгодог. Эдийн засагт гарч ирж байгаа энэ нэг жоохон нааштай үзүүлэлтүүдийг тогтворжуулах зайлиггүй хэрэг байна. Нэг.

Нөгөө талдаа бааз сууриа нь татварын бааз сууриа гэдэг юм уу энэ орлогын бааз сууриа нь тэлэх үйл явц руу бас бид дотоод нөөцөө жоохон дайчилмаар байна. Үүнийгээ бид зохистой хангалт хийх ёстой гэж. Нөгөө талд нь иргэдийн маань аж амьдрал тийм бас амаргүй байна. Үүнийгээ бид хийх ёстой. Тийм учраас Улсын Их Хурал дээр нэгэнт төсвийн хүрээний мэдэгдэл, төсөөлөл ярвж байгаа бол хэдүүлээ орлого талынхаа ч асуудлыг, зарлага талынхаа ч ерөнхий төсөөлж байгаа төсөөлөл, түүн дотор томсгосон тооцоогоороо энэ яригдаад байгаа асуудлыг дэмжих гэж ямар бодлогын зорилтууд чиглүүлж байгаа, түүнийг хангахын тулд ер нь ямархуу хэмжээний төсөөллийг багтаасан юм бэ гэдэг мэдээллээ өгөх ёстой. Энэ чинь ард түмэнд яах аргагүй хүлээлт байж байгаа зүйл гэдгийг 1 дүгээрт хэлмээр байна.

2 дугаарт, энэ хэдүүлээ хуулийн хязгаараар юм яриад байдгаа бас зарим тохиолдолд өөрчлөх ёстой. Дан дамаа энэ өрийн үлдэгдэл эд нарын асуудлыг бол бид хэд одоо 8,5, 8,1 тэрбум гээд ингээд л доллароор ярьцаагаад байгаа улсууд. Тэгвэл яг өнөөдөр 31 их наяд байгаа юм уу, 30 их наяд байгаа юм уу. Зайлиггүй 24 онд авах гээд байгаа хэрэгцээ маань хэд болчихоод байгаа юм. Түүнийгээ нэ нэмээд тооцохоор 34 их наяд болох юм уу, 35 их наяд болох юм уу. Тэрийгээ хэлээд тэр 60 дотор л багтаж байгаагаас хойш 57 гэдэг юм уу, 56 гэдэг юм уу, 53 гэдэг юм уу тэр бодит хувиар нь хэлмээр байна. Тэгэхгүй бол энэ чинь ард түмэнд буруу мэдээлэл өгөгдөөд тэгээд ер нь бас

сонгууль дөхчихсөн, одоо наадах дээр чинь тоглолт хийгээд энэ нөхдийг хар. Энэ улсын өрийг ийм байдлаар авч яваад ингээд байгаа улсууд аа гэдэг юм яригдаад болж өгөхгүй байгаа юм. Тийм учраас иргэд бас нэг үнэн бодитой мэдээлэл авах бас энэ улс орныхоо хөгжил гэдэг юм уу, аюулгүй байдлын талаар бас нэг сэтгэл эмзэглэлгүй амьдрах бололцоо боломжийг нь бид бүрдүүлж өгөх ёстой. Тийм учраас энэ хязгаартай үзүүлэлтүүдийг бол бодит байдалтайгаа нэлээн уях талынхаа асуудал руу ярих ёстой.

Тэнцлийн алдагдал дээр бол би мэдээж бидэнд хэрэгцээ ч байгаа, бодит өнөөдрийн суурь ч байж байгаа, энэ хоёрыгоо харьцуулж үзээд ер нь л болж өгвөл өнгөрсөн оны баталсан гүйцэтгэлээс л биет хэмжээгээр нь давууламгүй л байгаа. Би бол тэгж л бодож байгаа. Тэгж байж энэ улс орны эдийн засаг, төсөв өөрөө эрүүлжих тал руугаа явна. Дараа нь нэгэнт бий болчихсон жоохон энэ үр дүнг, тэгээд дан дамаа энэ заяагдмал баялгийн үр өгөөжийн тодорхой хэсгийг хуримтлал болгох, тэр хуримтлалынх нь тодорхой хэсэг иргэдийнхээ нэр дээр хуримтлал болдог. Тэгээд тэр хуримтлал нь эргээд дотоодынхоо хөгжлийн том төслүүдийг гэдэг юм уу, хөгжлөө тэтгэсэн эх үүсвэр болж ашиглагддаг зах зээлийнх нь зарчимд нийцүүлэх эрх зүйн том шинэтгэлийг маш шуурхай хиймээр байгаа юм. Энд бага, ихийн тухай ойлголт байхгүй. Зарчим нь зөв явбал жилээс жилд наад яригдаж байгаа тоон үзүүлэлтүүд нэмэгдээд, тодорхой нэлээдгүй хэсэг маань хуримтлалтай болох, нэлээдгүй хугацааны ар дээр бүх нийтээрээ хуримтлалтай болох, дотоодоосоо хөгжлийнхөө эх үүсвэрийг дайчилж болдог тэр үйл явц руугаа шилжих нэлээн том хөгжлийн шинэ чиг хандлага байх ёстой гэж ингэж хараад байгаа.

Тийм учраас би Эдийн засгийн яамыг, Сангийн яамыг, Засгийн газрыг ер

нь энэ тал руугаа хүрээнийхээ мэдэгдлийг батлуулж аваад л төсвийн боловсруулалтынхаа үйл явцтай давхар энэ чиглэлийн юмнуудаа тэмтэрч, эрх зүйн шинэ орчныхоо асуудал руу орох ёстой байх л гэсэн ийм байр суурьтай байна. Баярлалаа.

**Г.Тэмүүлэн:** Гишүүд санал хэлж дууслаа.

Тэгэхээр бас хэд хэдэн асуудлууд бол Байнгын хороон дээр гишүүдийн хэлсэн асуулт, санал дээр давхцаж байна. Нэг талдаа би нэг чиглэлийг бас Засгийн газарт болоод Сангийн яаманд чиглэл болгох гэж байгаа. Нэг бол энэ Улсын Их Хурлын 2017 оны 83 дугаар тогтоолын дагуу Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн зөвлөмжид ЗГ тайлбар ирүүлэх учиртай болсон байгаа. Тэгэхээр иймд маргааш Төсвийн хүрээний мэдэгдлийг Улсын Их Хурлаар хэлэлцэнэ. Тэгэхээр Засгийн газрын зүгээс маргаашийн чуулганы хуралдаанаар төсвийн хүрээний мэдэгдлийг хэлэлцэхээс өмнө тайлбарыг ирүүлэх чиглэлийг та бүхэнд бас өгч байна, 1 дүгээрт.

2 дугаарт, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн дагуу Эдийн засгийн хөгжлийн яамнаас ирүүлсэн макро үзүүлэлтэд үндэслээд энэ төсвийн тэнцвэржүүлсэн орлогын тооцоог маргааш чуулганаар хэлэлцэхээс өмнө хуульд нийцүүлж хийсэн аргачлал, тооцооллыг задалж Төсвийн байнгын хороонд ирүүлэхийг бас та бүхэнд даалгавар болгож байна. Тэр дундаа алтны тооцоог нарийвчилж тооцож ирүүлэх чиглэлийг бас Байнгын хорооноос болгож байгаа гэдгийг та бүхэн бас анхаарч авч үзээрэй.

Ингээд гишүүд асуулт асууж дууслаа. Санал хураалтыг явуулж эхэлье.

Ингээд Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг үзэл

*баримтлалын хүрээнд хэлэлцэхийг нь дэмжье гэсэн саналаар санал хураалтыг явуулъя. Санал хураалт.*

*Санал хураалтад 13 гишүүн оролцож, 9 гишүүн дэмжин 69,2 хувиар дэмжигдлээ.*

*Ингээд хуулийн төслийг хэлэлцсэн талаарх Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Батсуурь гишүүн танилцуулна.*

*Ингээд хуулийн төслийг хэлэлцэж дууслаа.*

*Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан байна. Хуралдаанд идэвхтэй оролцсон Байнгын хорооны гишүүд болоод ажлын хэсэгт баярлалаа.*

*14.21 цаг.*

**Дууны бичлэгээс буулгасан:**  
**ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ**  
**ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ**

**Э.СУВД-ЭРДЭНЭ**